

**“МАЛ АЖ АХУЙ ДАХЬ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР,  
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ  
АХУЙН НӨХЦӨЛ” СУУРЬ СУДАЛГАА**

*/тайлангийн хураангуй/*

**“МАЛ АЖ АХУЙ ДАХЬ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР,  
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН НӨХЦӨЛ” СУУРЬ  
СУДАЛГАА**

**Хянан тохиолдуулсан: Б.Минжигдорж**

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн О.Гомбо-Очир

Хэвлэлийн хуудас: 52

Цаасны хэмжээ: 210x297

Хэвлэсэн тоо: 350

АНУ-ын Хөдөлмөрийн департаментийн санхүүгийн дэмжлэгээр хэвлэв.

Хэвлэлийн “Эрдэнэзул” ХХК-д хэвлэв.

Улаанбаатар хот . 2009 он

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт

### НЭГ. УДИРТГАЛ

#### ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

- 2.1 Судалгааны зорилго
- 2.2 Судалгааны арга зүй
- 2.3 Судалгааны хамрах хүрээ, түүвэрлэлт
- 2.4 Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

#### ГУРАВ.СУДАЛГААНЫ ДҮН: МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ АЖИЛЛАДАГ ХҮҮХДҮҮДИЙН ДУНД ЯВУУЛСАН СУДАЛГААНЫ ДҮН

- 3.1 Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн нийгэм, хүн ам зүйн байдал
- 3.2 Мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүүхдүүдийн боловсрол
  - 3.2.1 Сургуульд хамрагдалтын түвшин
  - 3.2.2 Сургууль завсардалтын шалтгаан
  - 3.2.3 Албан бус боловсрол
- 3.3 Мал аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл
  - 3.3.1 Мал аж ахуйд ажилдаг хүүхдийн хөдөлмөр
  - 3.3.2 Мал аж ахуйд ажилдаг хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл, гэрээ, хөлс
  - 3.3.3 Мал аж ахуйд ажилдаг хүүхдийн хөдөлмөрийн аюулгүй байдал,
  - 3.3.4 Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн эрүүл ахуйн нөхцөл

#### ДӨРӨВ. МАЛ АЖ АХУЙД АЖИЛЛАДАГ ХҮҮХДҮҮДИЙН ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ДУНД ЯВУУЛСАН СУДАЛГААНЫ ДҮН

- 4.1 Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн нийгэм, хүн ам зүйн байдал
- 4.2 Малчин эцэг эхчүүдийн амьжиргааны эх үүсвэр
- 4.3 Хүүхдүүд мал аж ахуйн хөдөлмөр эрхлэх болсон шалтгааны талаарх эцэг эхчүүдийн санаа бодол
- 4.4 Мал аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн онцлог
  - 4.4.1. Хүүхдийг хэдэн наснаас мал аж ахуйн хөдөлмөрийн дадалтай болгож байна вэ?
  - 4.4.2. Айлд байж мал малладаг хүүхэд
  - 4.4.3. Мал маллаж байгаа хүүхдийн хөдөлмөрийн хөлс, ажлын нөхцөл
  - 4.4.4. Хүүхдийн ажил амралтын цаг
  - 4.4.5. Мал аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөрийн ялгаа
- 4.5. Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал

## **ТАВ. АЖИЛ ОЛГОГЧ НАРЫН ДУНД ЯВУУЛСАН СУДАЛГААНЫ ДҮН**

- 5.1 Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын нийгэм, хүн ам зүйн байдал
- 5.2 Айлд мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн талаарх ерөнхий мэдээлэл
- 5.3 МAA-д ажилдаг хүүхдүүдийн хөдөлмөр
  - 5.3.1 МAA-н ажил эрхэлж буй хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл
  - 5.3.2 МAA-н хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн хөдөлмөрийн хөлс
- 5.4 МAA-н хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн аюулгүй байдал

## **ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

- 6.1 Судалгааны дүгнэлт
- 6.2. Зөвлөмж

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АББ	Албан Бус Боловсрол
АБС	Албан Бус Сургалт
АББС	Албан Бус Боловсролын Сургалт
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАА	Мал Аж Ахуй
НХХЯ	Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам
ХХТХ	Хүүхдийн Хөдөлмөрийн Тэвчишгүй Хэлбэр
ХАА	Хөдөө Аж Ахуй
ТББ	Төрийн Бус Байгууллага
ҮСГ	Үндэсний Статистикийн Газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

Монгол Улс хүн ам цөөтэйн дээр нийт хүн амын 40.4 хувь буюу 1049.2 мянга нь 19 хүртэл насны хүүхэд, залуучууд эзэлдэг харьцангуй залуу хүн амтай орон юм. Түүнчлэн хүүхэд багачуудынхаа боловсрол, эрүүл мэндийн төлөө их анхаарал тавьж хүүхдэд ерөнхий боловсролыг үнэгүй олгодог, эрүүл мэндийг нь үнэ төлбөргүй хамгаалдаг орон. Гэсэн хэдий ч хүүхдийн эрхийг ямар нэгэн байдлаар зөрчих хөдөлмөрийг нь мөлжих, эрүүл мэндээр хохироох тохиолдол гарсаар байна.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага /ОУХБ/-ын Хүүхдийн хөдөлмөрийг утсгах хөтөлбөр /АЙПЕК/, Монгол улсын Засгийн газартай хамтран “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг дэмжих төсөл”-ийг 2005 оны 10 сараас эхлэн 2009 оны 12 сарын 31 хүртэл хэрэгжүүлж байна. Энэхүү АЙПЕК-ийн төслийн хүрээнд сонгон авсан аймаг, Улаанбаатар хотод алт, жонш, нүүрсний албан бус уурхай, хөлсний хөдөлмөрийн албан бус хэвшил (зах дээр ачаа зөөх, гэрийн үйлчлэгч хийх, хог хаягдал түүх), хөдөө аж ахуй (айлд мал маллах, тариа, ногооны талбайд удаанаар ажиллах г.м.), хүний үндсэн эрхийг зөрчсөн үйл ажиллагаа (бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах) зэрэг хэлбэрүүдэд илүүтэйгээр анхааран улсын хэмжээнд нийт 6000 хүүхдийг ХХТХ-ээс урьдчилан сэргийлж, хөндийрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна.

Үндэсний Статистикийн Газраас 2002-2003 онд Ажиллах хүчний судалгаатай хамтатган явуулсан. Хүүхдийн Хөдөлмөрийн анхны судалгааны тайланд Монгол Улсад 5-17 насны эдийн засгийн идэвхтэй нийт 68580 хүүхэд байсан бөгөөд тэдгээрийн дийлэнх нь буюу 91.7 хувь нь мал аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллаж байна<sup>1</sup> гэж мэдээлжээ. 2006-2007 онд хийсэн мөн судалгаагаар нийт 71330 хүүхэд эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 88,9% нь ХАА, ан агнуур, ойн аж ахуйд ажиллаж байна<sup>2</sup> гэжээ.

ХАА-д ажиллаж буй хүүхдийн хөдөлмөр, ахуйн нөхцөл байдлын талаар анхны судалгааг<sup>3</sup> АЙПЕК хөтөлбөрийн захиалгаар 2001 онд хийжээ.

Уг судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн бараг тэн хагас нь ямар ч цалин хөлсгүй ажилладаг. Төлбөртэй ажилладаг хүүхдүүдийн дийлэнх олонхи нь мөнгөн бус хэлбэрээр, ихэвчлэн хувцас, хоол хүнс хэлбэрээр хөлсөө авдаг байна. Бичгээр хийсэн гэрээ, хэлцэл байдаггүй тул хүүхдүүдэд төлж буй хөлс нь тэдний хийж буй ажилтай харьцуулахад маш бага байдгаас гадна хүүхдүүд, өөрийн эрхээ хамгаалах ямар нэг шаардлага тавих боломжгүй болдог гэсэн дүгнэлтийг хийсэн байна. Мөн ҮСГ-ын судалгаагаар ч хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 89,5% нь өрхийн үйлдвэрлэлд цалин хөлсгүй ажилладаг, 68,9% нь сургуулийн өмнөх насны хүүхэд байна<sup>4</sup> гэжээ. Тэрчлэн ХАА-д ажиллаж буй хүүхдүүд ихэвчлэн бага насны, сургууль завсардсан хүүхдүүд байдаг, ахлах ангийн хүүхдүүдийн хувьд ч бичгийн гэрээгүй ажилладаг нь харагдаж байна.<sup>5</sup> гэжээ.

Энэ бүхнээс үзэхэд малчны хүүхэд сургууль завсардан мал аж ахуйд хөдөлмөр эрхлэхээр хоцрох тохиолдол цөөн биш байгаа төдийгүй энэ талаарх ойлголт хангалтгүй байгаагийн дээр хүүхэд насандаа сурч хөгжих боломж нөхцөл хязгаарлагдаж улмаар хүүхдийн амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө бүхий тэвчишгүй хөдөлмөрийн хэлбэрүүд мал аж ахуйн салбарт байх магадлал өндөр байна. Ийм учраас мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн амьдрал, ахуйн нөхцөл, хөдөлмөр хамгаалал, эрүүл мэнд, боловсролын талаар цогц судалгаа явуулж нэгдсэн дүгнэлт гаргах явдал монголын нөхцөлд хүн амын хөдөлмөр, нийгэм хамгааллын хойшлуулшгүй зорилтын нэг болж байна.

1. - *НЭ Өзгөцөөний 2003 онд Монгол Улсад, 2003* 111,

2. - *НЭ Өзгөцөөний 2008 онд Монгол Улсад, 2008* 111

3. *Идэвхтэй 2003 онд Монгол Улсад. Ажлаагчид үйлдвэрлэлд 2003 онд Монгол Улсад, 2003* 111

4. - *НЭ Өзгөцөөний 2008 онд Монгол Улсад, 2008* 111

5. - *НЭ Өзгөцөөний 2008 онд Монгол Улсад, 2008* 111

## **Монголын МАА-н хөдөлмөрийн өнөөгийн байдал, онцлог, авч буй арга хэмжээ**

Монгол улс уламжлалт нүүдлийн бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг. 2008 оны эцсийн байдлаар 227.5 мянган өрхөд 43.3 сая мал тоологдсон бөгөөд тэдгээрт нийтдээ 360.2 мянган хүн хөдөлмөрлөж байна. Мал аж ахуйд хөдөлмөр эрхлэгч өрхийн 44.6 хувь нь 100 хүрэхгүй малтай ядуу амьдралтай. Нийт малчдын 46.9 хувь нь 16-35 насны, 40 хувь нь 36-55 насны, 13 хувь нь 56-аас дээш насны хүмүүс байгаа юм.

Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэл нь өвөл хаврын хүйтэн, зуд, цасан болон шороон шуурга, зуны хэт халуун, ган зэрэг байгаль, цаг уурын эрсдэл бэрхшээлтэй нөхцөлд явагддагийн хувьд хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамруулан үзэж болно.

УИХ-ын 2009 оны 39 дүгээр тогтоолоор “Малчдын талаар төрөөс баримтлах бодлого”-ыг батлан гаргаж малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллыг сайжруулах, нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх зэргээр тэдний тав тухтай амьдрах нөхцөлийг сайжруулахад чиглэсэн бодлогын үндсэн зорилтуудыг тодорхойлжээ.

Тус баримт бичигт мал аж ахуйн хөдөлмөрийн харилцааны хэв шинжийг судалж, туслах малчны хөдөлмөрийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчин бүрдүүлэх, хүүхэд хөдөлмөр эрхлэх нөхцөл, шалгуурыг тодорхой болгон тус салбар дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг арилгах бодлогыг хэрэгжүүлэхээр заасан нь чухал ач холбогдолтой юм.

Энэ бүхнээс үзэхэд манай оронд мал аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөрийн онцлогийг нарийвчлан судалж, нүүдэлчдийн амьдрал, уламжлал, зан заншлийг харгалзсан хөдөлмөр эрхлэлтийн зохистой хэлбэрийг эрж хайх, хүүхэд боловсролоор хоцрохгүй байх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэхэд илүү анхаарал тавих шаардлагатай болсон байна. Тулгарч байгаа зорилтыг хэрэгжүүлэхэд “Мал аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн нөхцөл” судалгаа чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй.

Энэхүү судалгаа нь НХХЯ, ХХААЯ, БСШУЯ-наас баталсан (2008 он) “Хөдөө аж ахуйн салбарт хүүхдийн хөдөлмөрийн талаар 2008-2009 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдэж байгаа юм.

### 2.1 Судалгааны зорилго

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь мал аж ахуйн салбар дахь хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг судалж, цаашид авах арга хэмжээний талаар санал зөвлөмж боловсруулахад оршиж байв. Судалгааны зорилгод үндэслэн дараахь зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Мал аж ахуйн салбарт хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн амьдрал, ахуйн нөхцөл, боловсролын байдлыг судлах,
- Мал аж ахуйн салбар дахь хүүхдийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг судалж дүгнэлт хийх,
- Судалгааны үрдүн, зөвлөмжийг үндэслэн МАА-д ажиллаж буй хүүхдийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах чиглэлээр цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны санал боловсруулж холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлэх.

### 2.2 Судалгааны арга зүй

Судалгаанд хоёрдогч мэдээллийн дүн шинжилгээ болон тоон судалгааны асуулга, харилцан ярилцлага, тохиолдол шинжлэх арга, ажиглалт, оролцооны судалгааны зураглал, баримтжуулалтын аргуудыг хослуулан хэрэглэж судалгааны үндсэн болон дэлгэрэнгүй мэдээллүүдийг цуглуулсан.

*Хоёрдогч мэдээллийн дүн шинжилгээгээр* хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримталж буй бодлогын баримт бичиг, статистик мэдээлэл, судалгаа шинжилгээний материалуудад дүгнэлт хийв. Асуулгын аргад мал малладаг хүүхэд, эцэг эх, ажил олгогч нарыг хамруулсан бөгөөд тус бүрд нь зориулсан асуулгын хуудсаар мэдээлэл авсан. Үүгээр МАА-н салбарт хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн сургуульд хамрагдалт, гэрээний нөхцөл, цалин хөлсний хэлбэр, ажил амралтын цаг, ачаалал, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдалт, эрхэлж буй хөдөлмөрөөс шалтгаалсан бэртэл гэмтэл, энэ тохиолдолд авч буй тусламж үйлчилгээ, эдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэлбэрүүд зэргийг хамруулан судлав.

*Экспертийн ярилцлагын аргад* судалгаанд хамрагдсан бүс нутгийн аймаг, сумын ЗДТГ, Хүүхдийн төлөө төв, сум, багийн Засаг дарга болон Хүнс, хөдөө аж ахуй, мал аж ахуй, нийгэм, эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулж хүүхдийн хөдөлмөрийн төлөв байдал, аймаг, орон нутгийн зүгээс мал малладаг хүүхдийн талаар явуулж буй бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг авлаа.

*Оролцооны судалгааны зураглал, баримтжуулалт, ажиглалт, кейс судалгааны аргуудаар* мал малладаг хүүхдүүдийн эрхэлж байгаа ажил, хөдөлмөрийн нөхцөл, албан бус сургалтанд хамрагдаж буй байдал, тэдний хүсэл сонирхол, ажлын төрөл, ачаалал зэргийг харуулахад чиглэсэн бодит, дэлгэрэнгүй мэдээллийг авсан билээ.

### 2.3 Судалгааны хамрах хүрээ, түүвэрлэлт

Судалгааг байгаль, газар зүйн бүс бүрийг төлөөлүүлэн Хэнтий, Төв, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл аймгийн бэлчээрийн МАА-н салбарын хүрээнд явуулахаар тооцож аймаг бүрээс 3, нийт 15 сумыг хамруулахаар арга зүйд тусгасан. МАА-н хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо харьцангуй цөөрсөн учир зайлшгүй шаардлагаар судалгааны явцад Говьсүмбэр, Дундговь аймгуудыг нэмж нийт 7 аймгийн 32 сумыг судалгаанд хамруулсан болно.

## Хүснэгт 2.1 Судалгааны хамрах хүрээ. (аймаг, сумдаар)

Үеi eí æ, үæ eí çañæ eí áçñ	Àeí àä	Ñoi ä
Ççí áçñ	Õyí ðeé	Õýðeýí, Áàýí ì ° í ò, Ààðòàí, Äýeäýðòààí, Æàðààeòòààí, Ì ° ð° í, Áàðí î ðí ä
Õ° àèeí áçñ	Õ° ä	Æàðààeàí ò, Áàðñçì áýð, Çààì àð, Àeòàí áóeàä
Õàí ààeí áçñ	<sup>a</sup> ä° ðòàí àäe	Áàýí ãí e, Ççí áàýí -òeààí, Áàýí ° í ä° ð, Í àðe eí òýýe, Áàð° eçeé, Öyí àà, Áðààe öýýð, Áàðóóí áàýí óeààí
<sup>a</sup> í ä° ð óóëúí áçñ	Õ° añä° e	Òàðe àeàí, Õ° ãí í öýí äýe, È õ-Óóe, Ðàø ààí ò
Ã àèeí áçñ	Äóí àäí äü	Ýðäýí ýàeàe, <sup>a</sup> eçeéò, Áàýí æàðààeàí
	<sup>a</sup> ì í ° ãí äü	Ì áí àäe-Î äí î, Áóeààí, Àäeàí çààààà, Õí àð-Î äí î
	Ã äü-Ñçì áýð	Ø eäýý-Î äí î, Ñçì áýð

Түүвэрлэлтийн эхний шатанд экологи, эдийн засгийн бүсийг төлөөлүүлэн 7 аймгийг сонгосон ба түүвэрлэлтийн дараагийн шатанд аймаг тус бүрээс сумдыг сонгохдоо дараахь үзүүлэлтүүдийг харгалзсан болно. Үүнд:

- Сумын нийт болон малчин өрхийн тоо,
- Хүн амын тоо, насны бүлэглэл, сургуулийн насны хүүхэд, сургууль завсардалт, мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо,
- Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, үүнээс МАА-н ажиллах хүчний хангамж,
- Сумын нийт малын тоо, төрөл зэрэг.

Мэдээлэл цуглуулалтын явцад орон нутагт МАА-н хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн талаар албан ёсны мэдээлэл бүрэн бус байсны улмаас судалгаанд хамруулах хүүхдүүдийн тоог урьдчилан төлөвлөсөн хэмжээнд хүргэхэд хүндрэлтэй байв.

**Хүснэгт 2.2 Судалгаанд хамрагдсан зорилтот хүн амын тоо, аймгууд болон судалгааны аргуудаар**

Судалгаанд асуулгын аргаар мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхэд 263, эцэг эх 220, ажил олгогч 57, нийт 540, ярилцлагын аргад 42 хүн бүгд 582 хүнийг хамруулав.

Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхэд, түүний эцэг эх, ажил олгогчийг судалгаанд хамруулахдаа сумдын ЗДТГ, багийн засаг дарга, сургуулийн нийгмийн ажилтан, албан бус боловсролын сургагч багш нарын туслалцаатай сонгож мэдээлэл авсан болно.

### 2.1 Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Тус бүр 4-5 хүний бүрэлдэхүүнтэй 7 баг 2008 оны 11 дүгээр сараас 2009 оны 2 дугаар сарын хооронд дээр дурдсан аймгуудад ажиллаж арга зүйн дагуу судалгааны ажлыг хийж гүйцэтгэв. Урьдчилан бэлтгэсэн 3 төрлийн асуулгын хуудсаар авсан тоон судалгааны мэдээллүүдийг нийгмийн судалгааны статистик мэдээлэл боловсруулалтын SPSS13 программд оруулан, энгийн статистик шинжилгээнүүдийг хийсэн болно. Тоон үр дүнгээр гарсан мэдээллийг баяжуулах, баталгаажуулах үүднээс судласан асуудлын хүрээнд явуулсан ярилцлагаар дэлгэрэнгүй мэдээлэл олж авсны зэрэгцээ зориуд эрж хайж олсон тохиолдлын зарим баримтыг кейс ишлэл болгон ашиглав.

## ГУРАВ. МАЛ АЖ АХУЙН ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮҮХДҮҮДИЙН ДУНД ЯВУУЛСАН СУДАЛГААНЫ ДҮН

Энэ хэсэгт мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын байдал, анхан шатны боловсрол, мэдлэгийн төвшин, сургууль завсардсан болон огт сургуульд сурдаггүй шалтгаан, тэдгээрийн дүйцсэн сургалтанд хамрагдсан байдал, ирээдүйн мэргэжлийн чиг баримжаа, эрүүл мэнд, хөдөлмөр, ахуйн нөхцөл зэргийг тодруулан судалсан судалгааны үр дүнг танилцуулах болно.

### 3.1 Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн нийгэм, хүн ам зүйн байдал

Асуулга судалгаанд хамрагдсан нийт 263 хүүхдийн 45.6 хувь нь Хэнтий, Хөвсгөл, 36.0 хувь нь Өвөрхангай, Төв, 18.4 хувь нь говийн бүсийн гурван аймгийн хүүхдүүд байв. Тэдгээрийн 77 хувь нь хөвгүүд, 23 хувь нь охид байсан бөгөөд 62.7 хувь нь 15-18 насны, 26.6 хувь нь 13-14 насны, 8.8 хувь нь 11-12 насны, 1.9 хувь нь 9-10 насны хүүхэд байв. Мал аж ахуйд ажиллаж байгаа хүүхдүүдийн бага нь 9 настай байхад ахлах нь 18 настай байлаа.

#### Хүснэгт 3.1

Мал аж ахуйд хөдөлмөр эрхэлж байгаа судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн нийгэм, хүн ам зүйн байдал, сонгосон үзүүлэлт, хувийн жингээр


МАА-н салбарт ажил эрхэлж байгаа хүүхдүүдийн дотор 9-12 насны хүүхэд 9.9 хувийг эзэлж байгаа нь ерөнхий боловсролын шатлалаар нь авч үзвэл бага боловсролын шатанд суралцаж байх ёстой хүүхдүүдийн эзлэх хувийн жин харьцангуй бага, харин дунд болон ахлах ангид суралцаж байх ёстой хүүхдүүд дийлэнх хувийг буюу 90.1 хувийг эзэлж байгаагийн олонх нь 15-аас дээш насны эрэгтэй хүүхдүүд байна.

**Энэ нь мал аж ахуйн салбарт 15-18 насны эрэгтэй хүүхдүүд гол ажиллах хүч нь болж байгааг харуулж байна.** Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувьд 44.1 хувь нь дундаж амьдралтай гэсэн бол 31.2 хувь нь амьдрал хүрэлцдэггүй гэж хариулсан нь өрхийн орлого багатай, амьжиргааны баталгаажих төвшингээс доогуур байх нь хүүхэд мал аж ахуйн хөдөлмөр эрхлэх нэг шалтгаан болж байна.

## 3.2 Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн боловсрол

### 3.2.1 Сургуульд хамрагдалтын төвшин

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 22.4 хувь нь ерөнхий боловсролын сургуульд суралцдаг, 33.9 хувь нь албан бус боловсролын дүйцсэн сургалтанд хамрагддаг гэж хариулсан бол 41.4 хувь нь сургууль завсардсан, 2.3 хувь нь огт сургуульд суралцаж байгаагүй байна. Энэ нь Үндсэн хууль, Боловсролын тухай болон Бага, дунд боловсролын тухай хуулиудад Монгол улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй гэж заасны дээр хэрэв хүүхэд сургууль завсардах, огт сурч байгаагүй тохиолдолд хүүхэд, насанд хүрэгчдэд орой, эчнээ, бусад хэлбэрээр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн эзэмшүүлэх буюу тусгай хөтөлбөрөөр мэдлэг олгох ёстой гэсэн заалт орон нутагт хангалтгүй хэрэгжиж байгааг



Сургуулийн насны хүүхдүүдийн боловсролын байдлыг илтгэх үзүүлэлтүүдийг судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн насны бүлгээр дээрх зурагт харуулав

Хөвсгөл аймгаас судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн (n=60) 95 хувь нь сургууль завсардсан гэж хариулсан нь анхаарал татахаар асуудал болж байна.

### Хүснэгт 3.2

--	--	--	--	--

## **Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн унших, бичих, тоо бодох чадвар, сургуульд хамрагдалтын төвшнээр, хувийн жингээр**

Зураг 3.3-т харуулснаар мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 39 хувь буюу 102 нь өөрийгөө сайн уншиж бичдэг гэжээ. Үлдсэн 54 орчим хувь нь ерөнхийдөө тааруу, 7 хувь нь буюу 18 хүүхэд уншиж чадахгүй гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн мөн 32 хувь нь өөрийгөө тоо бодохдоо сайн, үлдсэн 48 хувь нь дунд, 20 хувь нь буюу 53 нь муу, огт чаддаггүй хэмээн үнэлсэн байна.

Мал малладаг хүүхдүүдийн унших, бичих, тоо бодох чадварт тухайн хүүхдийн сургуульд сурсан хугацаа, дүйцсэн сургалтад хамрагдсан байдал чухал нөлөө үзүүлж байна. Тухайлбал ЕБС-д суралцдаг хүүхдүүдийн бичиг үсгийн болон тоо бодох чадвар нь харьцангуй сайн, сургууль завсардсан болон огт сургуульд суралцаж байгаагүй хүүхдийн унших, бичих, тоо бодох чадварын төвшин доогуур байна. Муу уншдаг гэж хариулсан 45 хүүхдийн 72.1, уншиж бичиж чадахгүй гэж хариулсан 18 хүүхдийн 62.4 хувь нь сургууль завсардсан хүүхдүүд байна.

Тоо муу боддог гэж хариулсан хүүхдүүдийн 64.3 хувь нь, тоо бодож чаддаггүй гэж хариулсан хүүхдүүдийн 77.7 хувь нь сургууль завсардсан буюу дүйцсэн сургалтанд хамрагдсан хүүхдүүд байна. Ийнхүү сургууль завсардсан, огт сургуульд сураагүй, мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн унших, бичих, тоо бодох чадвар доогуур байгаа нь Боловсролын тухай хууь, Хүүхдийн эрхийн конвенцид заасан сурах эрхээ мал малладаг хүүхэд эдэлж чадахгүйд хүрч байгааг харуулж байна.

### **3.2.2 Сургууль завсардалтын шалтгаан**

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 61 хувь нь хүн бүр заавал суурь боловсрол буюу 9 жилийн боловсрол эзэмших үүрэгтэйгээ мэддэг, харин 39 хувь нь ийм үүрэгтэйгээ мэдэхгүй гэж хариулсан бөгөөд тэдний 67.9 хувь нь сургууль завсардсан, бусад нь сургуульд огт сурдаггүй хүүхдүүд байв.

Түүнчлэн судалгаанд хамрагдсан сургууль завсардсан болон дүйцсэн сургалтанд хамрагддаг хүүхдүүдийн 27.6 хувь нь сурах сонирхолгүй гэсэн бол 22.6 хувь нь хэдийгээр сурах сонирхолтой боловч гэр бүлд нь мал маллах өөр хүнгүйгээс цаашид сурах боломжгүй гэжээ.

Сургууль завсардсан шалтгааны дотор **сурах сонирхолгүйгээс болж сургуулиа орхин мал маллах болсон** гэсэн хариулт хамгийн том байр суурийг эзэлж байна. 9-10 насны хүүхдүүд өвчний улмаас, 15-18 насны хүүхдүүд сурах сонирхолгүйгээсээ болж сургууль завсардсан гэсэн нь түгээмэл ажиглагдлаа. Түүнчлэн суурь боловсролыг 6 наснаас нь эхэлж олгох болсоны зэрэгцээ дотуур байр, сурах бичиг хангалтгүй, гэр бүлийн тав тухгүй байдал зэрэг нь малчдын хүүхдийн бага, дунд боловсрол эзэмшихэд бэрхшээл учруулж болзошгүй байгаа юм.

### **Хүснэгт. 3.3.**

**Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд хэддүгээр ангиас сургууль завсардсан , хувийн жингээр**

Сургууль завсардсан хүүхдүүдийн зөвхөн 21 хувь нь сургуульд дахин сурахаар санал хүсэлт гаргаж байснаас харвал сургууль завсардсан хүүхэд дахин сургуульд суралцах магадлал бага байна гэж үзэж болно. Сургууль завсардсан хүүхдийг улирсан гээд шоолдог, дооглодог зэрэг шалтгааны улмаас дахин суралцах сонирхолгүй гэж хариулж байлаа. Үүнд орон нутгийн засаг захиргааны байгууллагын хайхрамжгүй байдал, уг ажлыг зохион байгуулж байгаа арга барилын доголдол ч ямар нэг хэмжээгээр нөлөөлж байгаа нь ажиглагдаж байна.

### **3.2.3 Албан бус боловсрол**

2006 онд баталсан Монгол Улсын 2006-2015 онд хэрэгжүүлэх Боловсролын салбарын мастер төлөвлөгөөнд суурь боловсролыг хугацаандаа эзэмшиж чадаагүй залуучуудад боловсрол нөхөн олгох боломжийг бий болгох, АББ-ын бүх төвшинд сургалтын орчин, чанарыг сайжруулж, нөөцийн чадавхыг дээшлүүлэх, АББ-ын гэгээрлийн төвүүдийн хүчин чадал, нөөцийг нэмэгдүүлэх замаар сургалтын орчинг сайжруулах, АББ-ын тогтолцооны бодлого, стратегийг боловсронгуй болгож, мэдээллийн болон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх зэрэг малчин хүүхдүүдэд суурь боловсрол нөхөн эзэмшүүлэхтэй холбогдсон заалтууд орсон билээ.

Судалгааны явцад орон нутгийн төр, захиргааны болон боловсролын байгууллагуудаас сургууль завсардсан, эсхүл сургуульд сурч байгаагүй хүүхэд, насанд хүрэгчдэд орой, эчнээ, бусад хэлбэрээр бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох талаар тавигдаж байгаа зорилтыг хэрэгжүүлэхэд анхаарч зарим ажил хийж байгаа нь харагдаж байв. Тухайлбал, Хэнтий аймгийн боловсролын газар АББ-ын сургалтанд хамрах хүүхдийг сум бүрээр нэг бүрчлэн нэр, нас, хүйсээр нь компьютерийн сүлжээнд бүртгэж, зохих хөтөлбөрийн дагуу суралцаж байгаа эсэхэд нь хяналт тавьдаг болсон, Дундговь аймгийн засаг дарга 2007 онд албан даалгавар гаргаж, сургуулийн насны хүүхдийг сургуульд бүрэн суралцуулах, МАА-д ажиллаж буй хүүхдүүдийг албан бус боловсролын сургалтад хамруулах ажлыг сумдын Засаг дарга, багийн дарга, сургуулийн захирал нарт хариуцуулан үр дүнг нь тооцож байна. Өмнөговь аймгийн Засаг дарга энэ асуудлыг сумдын засаг дарга нартай байгуулах гэрээнд тусгаж үр дүнг тооцдог болжээ.

**Судалгаанд хамрагдсан 13-14 насны хүүхдүүдийн 82.1 хувь нь, 15-18 насны хүүхдүүдийн 74.9 хувь нь ЕБС-д суралцаагүй бөгөөд эдгээр хүүхдүүдийн дийлэнх нь бага ангидаа сургууль завсардсан байлаа. ЕБС-д суралцаж байгаагүй хүүхдүүдийн 74.5 хувь нь албан бус сургалтанд хамрагдах сонирхолтой гэж хариулснаас үзэхэд сургуульд сурах хүсэл эрмэлзлэл байгааг харуулж байна. Гэвч хүүхдүүдэд хүсэл сонирхол байгаа боловч үнэн хэрэгтээ албан бус боловсролын чанар, сургалтын арга барилыг сайжруулах шаардлага байгаа нь анзаарагдаж байлаа.**

**Ирээдүйдээ ямар мэргэжилтэй болох сонирхолтойг тандахад нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 21.3 хувь нь малчин болно гэсэн бол үлдсэн хувь нь хотын хүүхдүүдийн адил багш, эмч, барилгачин гэсэн нийтлэг мэргэжлүүдийг нэрлэж байв. Тэднээс 50 нь буюу 19.0 хувь нь ямар мэргэжилтэй болохоо мэдэхгүй байна. Өөр бусад ямар мэргэжил байдгийг ч тэд нэрлэж чадахгүй байв. Иймд “малчин” гэдгийг уламжлалт мал аж ахуйгаа орчин цагийн арга технологиор баяжуулан зах зээлийн нөхцөлд нийцүүлэн үр ашигтай эрхлэх чадвар бүхий мэргэжилтэн гэж үзэж баталгаажуулах шаардлагатай байна. Түүнчлэн малчин хүүхэд, залуучуудад ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөх сургалт, ялангуяа тэдний сурч боловсрох эрх, үүрэг, боловсрол эзэмшихийн ач холбогдол, эерэг үр нөлөөний талаар мэдээлэл өгөх үйлчилгээ дутагдаж байгааг анхаарах цаг болжээ.**

**Мал малладаг хүүхдүүдийн эзэмшихийг хүсч байгаа мэргэжил, хувийн жингээр**

Ямар мэргэжилтэй болохоо мэдэхгүй байна гэж хариулагчдын дотор сургууль завсардсан хүүхдүүдийн эзлэх хувийн жин өндөр байлаа.

Иймд цаашид орон нутгийн засаг захиргаанаас боловсролын бодлогыг хэрэгжүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх шаардлагатай. Магадгүй энэ чиглэлээр Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв, боловсролын байгууллагатай хамтран ажиллах хэрэгтэй байж болох юм.

Сүүлийн жилүүдэд МАА-н хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо харьцангуй цөөрсөн гэж орон нутгийн холбогдох албан тушаалтнууд үзэж байна. Ялангуяа 2000 оны зуднаас хойш малчид МАА эрсдэлтэй гэдгийг ухаарч хүүхдүүдээ аль болох боловсролтой болгох хандлагатай болжээ. Албан бус сургалтаар боловсрол эзэмшүүлэх боломжтой боловч байнгын албан ёсны сургалт нь дээр гэж үздэг учраас хүүхдийг аль болохоор сургууль завсардуулахгүй байхыг хичээх болжээ.

Судалгаанд хамрагдсан сумдад АББС-ыг жилд хоёр удаа, тус бүр 14 хоногийн хугацаатай зохион байгуулдаг байна. Гэвч Өмнөговь, Дундговийн сургуулиуд АББС-аар суралцаж буй хүүхдүүдэд сурах бичгийг тавьж өгдөггүйгээс тэдний биеэ дааж суралцахад бэрхшээл учруулдаг байна. Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын дунд сургууль албан бус сургалтад зориулж Гэгээрлийн танхим байгуулан ажиллуулж байгаа нь дэмжүүштэй эхлэл санаачлага байв. Харин олонхи сургуулиуд АББС-ын багш нарт давхар ажил хариуцуулж байгааг багш, эцэг эхчүүд шүүмжилж байв.

Хэдийгээр малчдын хүүхдүүдийг албан болон албан бус сургалтад хамруулах талаар дэвшил гарч байгаа ч хөдөлмөр, боловсрол, хүүхдийн байгууллагуудын дунд МАА-н хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал эзэнгүйдэж байгаа нь ажиглагдлаа. Ялангуяа аймаг, сумдын ЗДТГ-т энэ талаар тодорхой мэдээлэл, судалгаа хомс байна. Цаашид албан бус хэлбэрээр боловсрол эзэмшиж буй хүүхэд, өсвөр насныхан болон насанд хүрэгчдийг тус бүрт нь анги танхимаар хангахад орон нутгийн засаг захиргааны зүгээс анхаарах хэрэгтэй байна.

**3.3 Мал аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл****3.3.1 Мал аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөр**

Асуулгын дүнгээс үзэхэд мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүүхдүүдийн хамгийн

бага нь 4 наснаасаа мал аж ахуйн ажилд тусалж эхэлсэн байхад 60 хувь нь 7-9 наснаасаа эхэлсэн гэж хариулсан байна.

### Хүснэгт 3.5.

#### **Мал аж ахуйд тусалж эхэлсэн болон бие дааж мал маллаж эхэлсэн нас, нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хариултын хувийн жингээр**

Хүснэгтээс үзэхэд мал аж ахуйн ажилд элбэлцэх болсон дундаж нас 8 байхад бие дааж мал маллах болсон нас 10 байлаа. Эдгээр нас нь монголчуудын уламжлалт заншлын үүднээс мал аж ахуйд туслахад боломжтой гэж тооцогдох боловч хүүхдийн хөдөлмөрийн талаарх олон улсын хэм хэмжээтэй харьцуулвал зөрчилдөж байгаа юм. Тухайлбал Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар Конвенцид зааснаар буурай хөгжилтэй улс орнуудад хүүхэд хөнгөн ажил эрхлэх насны доод хязгаарыг 15 гэж тогтоосон байна. Гэвч хүүхэд ямар нөхцөлд тухайн ажлыг гүйцэтгэж байна, дэргэд нь хэн зөвлөн тусалж байна, хэр олон цаг ажиллаж байна зэрэг нөхцөл, хамгаалалт, ажлын мөн чанар, зорилго зэрэг олон үзүүлэлтийг харгалзаж үздэг.

Эдгээрийг үндэслэн хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хохирол учруулж болзошгүй ажилд 18 наснаас доош насныхныг ажиллуулахыг хориглосон байдаг. Иймд цаашид эрх зүйн хүрээнд хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйн салбарт хүүхэд ажиллах нөхцөл, шалгуурыг тодорхой болгож, ямар хэлбэрийн хөдөлмөрийг зөвшөөрөх, алийг нь хориглох тухай зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлагатай байгаа юм.

**Судалгаанд хамрагдсан хүүхдийн 69.6 хувь нь өөрийн гэртээ байж мал малладаг бол 30.4 хувь нь айлд амьдарч мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг нь ихээхэн анхаарал татаж байна** Өөрийн гэрээс өөр орчинд ажиллах нь далд хэлбэрээр хүүхдийн хөдөлмөрийг мөлжих, хүүхдийн үндсэн эрхүүдийг нь зөрчихөд хүргэдэг тул олон улсын түвшинд уг асуудалд илүү нухацтай ханддаг. Тухайлбал, НХХ-ийн сайдын 2008 оны 107 тоот тушаалаар баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-д өрхөөс өөр орчинд гэрийн үйлчлэгч хийхийг хориглосон байдаг. Үүнтэй мөн чанараар ижил тул айлд байж мал маллахыг ч бас анхаарч үзэх учиртай. Гэхдээ хөдөлмөр ахуйн нөхцөл, хамгаалалт, аюулгүй байдал, үргэлжлэх хугацаа, хэв шинжийг харгалзан үзэхийн хамт тэдний цалин хөлс, гэрээ хэлцэл зэрэг олон асуудлыг хөндөж, илүү тодорхой, зохицуулалт шаардлагатай болж байгаа нь энэхүү судалгаанаас харагдаж байна.

**Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн мал маллах хугацаандаа амьдардаг газар, байршлаар**

Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 17.0 хувь нь өвөө, эмээ, хамаатан садныдаа, 10.3 хувь нь ажил олгогчийндоо амьдрангаа малыг нь маллаж байна. Тэгэхээр айлд мал малладаг хүүхдүүдийн гол ажил олгогч нь ах эгч, авга, нагац болон эмээ, өвөө гэсэн хамаатан садан нь байдаг боловч ийм тохиолдолд хүүхдийн эрх ашиг хамгаалах асуудал улам бүр бүрхэг болдгийг судалгааны дүн харуулж байна. Тухайлбал, тэдний хөлсгүйгээр ажиллах хугацаа, давтамж, эрсдэлтэй байдал нэмэгдэж байна. Харин хамаатан бус айлд хамгийн бага нь нэг жил, дээд тал нь 10 жил ажилласан хэмээн хариулжээ.

Мал малладаг хүүхдүүдийн өдөрт ажилладаг цагийг байршлаар болон насаар нь харьцуулан шинжилснийг 3.7, 3.8 зургаар илэрхийлэв. Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн олонхи нь 9-12 ба түүнээс дээш цагаар ажилладаг гэж хариулснаас үзвэл ажлын цаг урт байгааг харуулж байна.

Сургууль завсардсан болон дүйцсэн сургалтанд суралцдаг хүүхдүүдийн 69.6 хувь нь 1-4 дүгээр ангиасаа сургууль завсардсан байна. Өөрөөр хэлбэл ЕБС-ийн бага боловсролын шатанд хүүхдүүд мал маллахаар сургууль завсардах үзэгдэл илүүтэй байна. Асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас үзэхэд зах зээлийн шилжилтийн эхэнд нэгдэл, сангийн аж ахуйн малыг хувьчлах үед малчид эрэгтэй хүүхдээ сургуулиас гаргаж МАА-н хөдөлмөр эрхлүүлэх сонирхол нэлээд түгээмэл байжээ.

Судалгааны мэдээлэл цуглуулах үеэр зарим аймагт сургуулийн дотуур байрны хүүхдүүд шалан дээр сууж хичээлээ хийж байсан билээ. Хүүхэд 6 наснаас нь ЕБС-д сургах болсноор дотуур байрны хүрэлцээ улам муудсан, дээр нь малчин өрх хоёр тасарч гэрийн эзэгтэй нар сумын төв дээр хүүхдээ харж, өрхийн тэргүүнүүд нь хөдөө малаа маллах болсон тохиолдол олон байна.

**Кейс:** Малчин өрх сургуулийн хүүхдээ даган хөдөө, сумын төвд 2 тасран амьдрах болсноор өрхийн зардал ихэсч байгаа, сумын төвөөс 10 км-ын радиусад байгаа малчид оройд малаа эзгүй хашчихаад сумын төвд давхиад ирдэг болсон. Нөхрүүд нь гэргий нараа 'үдэш оройд үзвэр үдэшлэг эргүүлээ' гэж муудалцах, архи хэрэглэх зэрэг хөдөөгийн малчин өрхүүдэд 'нийгмийн шинэ асуудал' үүсч байна. Засгийн газар, боловсролын байгууллагууд дунд сургуулиудын дотуур байрны хангамж, аюулгүй байдал, тохижилтыг сум нэг бүрээр шалгаж шаардлагатай арга хэмжээ авууштай байна.

(Ганцаарчилсан ярилцлага, Өмнөговь аймгийн Булган сумын Дэн багийн засаг дарга)



Тэрчлэн мал малладаг хүүхдүүдийн насны бүлэг дээшлэх дутам уртасгасан цагаар ажиллах нь нэмэгдэж байгаа дүр төрх ажиглагдаж байна. **Тухайлбал хоногт 9-12 цагаар ажилладаг гэж судалгаанд хамрагдсан 15-18 насны нийт хүүхдүүдийн тал хувь нь, 13-14 насны хүүхдийн 43.3 хувь нь хариулжээ.** Мөн хүүхдийн 6.8 хувь нь 13, түүнээс дээш цагаар ажилладаг гэсэн хариултыг өгчээ.

Судалгаанд хамрагдсан өсвөр /13-14 / насныхны 85.1 % нь өдөрт доод тал нь 5-8 цаг ажиллаж байгаа нь 7 хоногт ажиллавал зохих хүүхдийн хөдөлмөр 30 цагаас илүүгүй байхаар заасан Хөдөлмөрийн тухай хууль болон олон улсын конвенци бусад холбогдох хуулийн заалтуудтай шууд зөрчилдөж байна.

### ***3.3.2 Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл, гэрээ, хөлс***

Мал аж ахуйн салбарт ажиллаж буй хүүхдүүдийн хувьд ажил олгогчтой хийх хөдөлмөрийн гэрээний нөхцөл, хөдөлмөрийн хөлс, урамшууллын асуудал хамгийн их анхаарал татсан асуудал болж байгааг энэхүү судалгааны дүн харуулж байна

**Айлын мал малладаг хүүхдүүдийн 57 хувь нь тэдний эцэг эх нь ажил олгогчтой аман тохиролцоо хийдэг,** 22,0 хувь нь мал малладаг хүүхэдтэй өөртэй нь тохиролцдог, 21,0 хувь нь ямар нэгэн гэрээ хэлцэл огт хийгээгүй гэж хариуллаа. (Зураг 3.9) Хэдийгээр эцэг эх, харгалзан дэмжигч нь хүүхдээ төлөөлөн ажил олгогчтой аман тохиролцоо хийдэг ч хүүхдийн ажлын хөлс, нөхцөл, хамгаалалт, аюулгүй байдлыг орхигдуулдаг байна. Мөн 16-аас доош насны хүүхдүүд бие даан хөдөлмөрийн болон иргэний харилцаанд оролцох боломжгүй тул хүүхэдтэй хийж буй аман тохироо, гэрээ хэлцэл нь эрх зүйн хувьд хүчин төгөлдөр гэж үзэх үндэслэлгүй байна.

Харин мал аж ахуйн ажлыг дадлага олгох зорилготойгоор хийж байгаа гэж үзэх тохиолдолд 14 насанд хүрсэн хүүхэдтэй эцэг эхийн зөвшөөрлөөр хөдөлмөрийн гэрээ хийж, нөхцөл, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах боломжтой байдаг. Гэвч мал аж ахуйд хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд нь ямар ч эрх зүйн хамгаалалтгүй болох нь судалгааны явцад харагдлаа. **Өнөө үед хамгийн тулгамдаж буй ийм гэрээ, хэлцлийн загварыг гаргаж мөрдүүлээгүй байна.** Өөрийн малаа малладаг хүүхдүүдийн хувьд гэрээ хэлцэл, хөдөлмөрийн хөлсний талаар ямарч төсөөлөлгүй байлаа.

**. Бусад айлын мал малладаг хүүхдүүдийн хөдөлмөрийн гэрээ, хэлцэл хийсэн байдал (байршлаар)**

Насны бүлэг нэмэгдэх тусам огт гэрээ хэлцэл хийгээгүй гэж үзсэн хариултын хувийн жин өсч байсан.

**Жишээ:**

*Гэрээ, хэлцэлийн тухай би сайн мэдэхгүй. Манай аав ээжтэй л тохирсон байх, би өөрөө тэгээд ч малд дуртай. Энэ айл надад хувцас авч өгдөг, жилдээ бяруу, шүдлэн өгнө гэсэн.*

*(Ганцаарчилсан ярилцлага, Төв аймгийн Батсүмбэр сум, мал малладаг эрэгтэй хүүхэд, 15 настай)*

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн талаас илүү хувь нь ажлын хөлс, урамшууллын талаар ямар нэг тохиролцоо байдаггүйг судалгаа харуулж байна.

**Айлд мал маллаж байх хугацаандаа ажил олгогчтой хүүхэд болон эцэг эхийн тохиролцдог нөхцөлүүд /хувиар/**

**Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаа нийт хүүхдүүдийн 45% цалин хөлсний хэмжээг аман хэлбэрээр тохирдог** гэж хариулсан нь тохиролцооны хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Хүүхдүүдийн цөөнх хэсэг нь ажил олгогчтой зөвхөн цалин хөлсний хэмжээг тохирдог боловч сурч боловсрох, эрүүл байх, ажлын орчин, ачааллаа зохицуулах зэрэг үндсэн эрхтэй холбоотой нөхцөлүүдийг аль нь ч хөнддөггүй, хоёр тал зөвхөн эдийн засгийн ашиг сонирхол дээр санал нэгддэг байна. Нөгөөтэйгүүр хүүхдийн сонирхлыг харгалзалгүйгээр ажил олгогч зөвхөн өөртөө ашигтай, нэг талын давуу байдлыг тулгадгийг үгүйсгэх аргагүй юм. Ийм хэлбэрийн тохироо нь хүүхдийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй байна.

Ажил олгогч хүүхэд ажиллуулж байгаа атлаа гэрээ, хэлцэл хийхгүй байгааг хүүхдээс асууж тодруулсныг Зураг 4.10-т харууллаа.



Хөдөлмөрийн гэрээ хийхгүй байгаагийн учрыг хүүхдүүд тайлбарлахдаа энэ талаар хэлж мэдэхгүй байна, өөрийн хүслээрээ ажилладаг тул, хамаатны айл тул гэрээ хэлцэл хийдэггүй гэж үзэж байгаа нь илүүтэй байна.

**Айлын мал малладаг хүүхдүүдийн 30 хувь нь мөнгөн хэлбэрээр, 63.8 хувь нь бэлэн бус хэлбэрээр хөлс авдаг, үлдсэн 6.2 хувь нь ямар нэгэн зүйл авдаггүй байна.** Мөнгөн хэлбэрээр ажлын хөлсөө авдаг гэж хариулсан хүүхдүүдийн хувьд сард дунджаар 53000 төгрөг, хамгийн бага нь 1000 төгрөг, дээд тал нь 200000 төгрөг айлд авдаг байна. Ийнхүү харилцан адилгүй ажлын хөлс авч байгаа нь шударга бус бөгөөд хүүхдийн хөдөлмөрийг мөлжиж байгаа нэг хэлбэр юм.

Ер нь газар зүй, эдийн засгийн бүс болон орон нутгийн ялгаатайгаар зөвхөн хүүхэд төдийгүй насанд хүрсэн малчдын хувьд ч мал аж ахуйн үйлдвэрлэлд ажлын төрөл, нөхцөл, хэв шинжийг харгалзан цалин, хөлсний үнэлэмжийг бий болгох явдал зайлшгүй чухал байна. Мөнгөн бус хэлбэрээр ажлын хөлсөө авдаг гэж хариулсан хүүхдүүдийн хувьд хоол хүнс, хувцас, хичээлийн хэрэгслэл зэрэг зүйлсийг авч байгааг судалгаа харуулж байлаа.

**Ажлын хөлсөө мөнгөн бус хэлбэрээр авдаг хүүхдүүдийн урамшууллын хэлбэрүүд**

*Тайлбар: Олон сонголттой хариултын хувилбараар хариулсан тул 100 хувьтай тэнцэхгүй*

Мөн сард нэг хонь, даага авдаг, хурдан морь унадаг бол бай мөрийнээсээ авдаг гэж зарим хүүхдүүд хариулж байлаа.

Мал малладаг хүүхдүүд ямар хугацаагаар цалин хөлсөө авч байгааг дараахь 4.11 зурагт харуулав.

Хамаатныдаа эсвэл бусад айлын мал малладаг хүүхдүүдийн 30.9 хувь нь сар бүр, 27.2 хувь нь жилдээ нэг удаа, 27.2 хувь нь улиралд нэг удаа, 11.1 хувь нь хагас жилд нэг удаа ажлын хөлсөө авч байна. Мал маллаж ямар нэгэн хэлбэрээр хөлс, урамшуулал авдаг гэж үзсэн хүүхдүүдийн 13.1 хувь нь ажил олгогч тогтсон хугацаандаа хөлсөө төлөхгүй байх тохиолдол гардаг гэжээ.

Үүнээс үзэхэд үйлдвэрлэлийн болон уламжлалын онцлогийг харгалзан олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн гэрээ, хэлцлийн зохистой загварыг бий болгож, ажил олгогч, малчдын үүрэг, хариуцлага, эрхийг хууль зүйн хувьд баталгаажуулахад анхаарах хэрэгтэй байна.

**3.3.3. Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн хөдөлмөрийн аюулгүй байдал болон тохиолддог бэрхшээл.** Энэ хэсэгт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хөдөлмөр эрхэлж байх үеийн нөхцөл байдал, тэдэнд тохиолддог бэрхшээл, ажил олгогчийн зүгээс хүүхдийг дарамтлах тохиолдол гардаг эсэх, ажил эрхлэх явцад хүүхдийн аюулгүй байдал, ажлын хувцас хэрэгслэлийн хангамж ямар байгааг авч үзлээ.

### **Хүснэгт 3.10. Мал малладаг хүүхдүүдийн өглөө босдог болон орой унтдаг цаг, баярын өдрүүдэд амардаг эсэх (хүүхдийн хариултын хувийн жингээр)**

Мал малладаг хүүхдүүдийн 82.2 хувь нь өглөө 7-8 цагт босдог, харин 57.0 хувь нь 22-23 цагт ундаг гэж хариулсан байна. Насны бүлэг ахих тусам орой унтдаг гэсэн хариултын хувийн жин өсч байлаа. Өөрөөр хэлбэл бага насны хүүхдүүд арай эрт унтаж байхад 13-аас дээш насныхны унтах цаг нэлээд хойшилж байсан. Өглөө эрт 5-6 цагт босдог гэж хариулагчдын дотор ахлах насны хүүхдүүдийн эзлэх хувийн жин өндөр байна.

**Хүүхдүүдийн өглөө босч байгаа цаг дундажаар 7, орой унтаж байгаа цаг дундажаар 22 цаг тус тус байна.** Үүнээс үзэхэд хүүхдүүд нэлээд уртасгасан цагаар ажилладаг болох нь харагдаж байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 42.2 хувь нь ямар нэгэн тэмдэглэлт өдрүүдээр амардаггүй гэсэн ба хүүхдүүдийн нэлээд нь цагаан сар, наадам зэрэг үндэсний баяраар амардаг байна. Харин морь унадаг хүүхдүүдийн хувьд наадмын үеэр амардаггүй хэмээн хэлж байсан билээ.

Судалгаанд хамрагдсан малчин хүүхдүүдийн нэг ажлаас дараагийн өдрийн ажил хүртэл амрах хугацаа нь Хөдөлмөрийн хуулиар тогтоосон доод хугацаа болох 12 цагаас бага, нийтээр амрах баяр ёслолын болон амралтын өдрүүдэд амрах боломжгүй байдаг зэрэг нь хөдөлмөрлөх үндсэн хэм хэмжээг зөрчиж байгааг харуулж байна. Энэ нь хэдийгээр үйлдвэрлэлийн онцлогтой холбоотой боловч хөдөлмөрийн харилцааны үндсэн хэм хэмжээ мөрдөгдөхгүй байна гэж үзэх үндэслэлтэй юм.

Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдээс 10 хүрэхгүй хүүхэд өлсөж цангах, даарч хөрөх бэрхшээл нэлээд тохиолддог гэж хариулсныг эс тооцвол ийм тохиолдол гардаггүй гэж дийлэнх хүүхэд хариулсан байна. Гэвч мал аж ахуйд ажиллаж байгаа хүүхдүүдийн хувьд үйлдвэрлэлийн, бие махбод, сэтгэл зүй, амь насны болон нийгмийн орчны талаас эрсдэлтэй байдал, хувь хүний хариуцлага талаас бэрхшээл учирдаг явдал олонтоо байдгийг зураг 4.12-оос харж болно.

Айлын мал малладаг хүүхдүүдийн дийлэнх нь ямар нэг бэрхшээлтэй тохиолдол гардаг гэж хариулсан билээ. (Зураг 3.12)

Хамгийн их тохиолддог бэрхшээл нь цас, шуурга, бороотойд малтайгаа өртөх, мал нь алга болох, хэрэв мал нь алга болбол төлөх нь тэдэнд тохиолддог гол бэрхшээл болж байна. Түүнчлэн өлсөх, даарах, хөдөө малаа хариулж явах үеэр айх, ядрах зэрэг нь хүүхдүүдийн хувьд хүндрэлтэй асуудлын тоонд орж байна.

Хүүхдүүдэд тохиолдож буй бэрхшээл нь насны ялгаанаас хамаарах хандлагатай байгаа нь бага насны хүүхдүүд (9-10 настай) ядардаг гэж хариулсан бол ахлах насны хүүхдүүдийн (15-18 нас) хувьд цас бороонд малаа алдах явдал илүү хэцүү гэж үзснээс харагдаж байна. Үүнээс гадна судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 6.8 хувь нь эцэг эх, асран хамгаалагч болон ажил олгогчдоо загнуулдаг, зодуулдаг гэж хариулжээ. Хэдийгээр энэхүү үзүүлэлт нь нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдтэй харьцуулахад бага боловч мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүүхдүүд загнуулах, зодуулах хэлбэрээр дарамтлуулах, хүчирхийлүүлэх явдал байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан бүх хүүхдүүдээс мал аж ахуйн салбарт хөдөлмөрлөхөд хамгийн хэцүү зүйл юу болохыг асуусныг дараахь зурагт харуулъя.

Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 33.3 хувь нь мал аж ахуйд ажиллахад ямар нэгэн бэрхшээл гардаггүй гэж үзсэн бөгөөд эдгээр нь ихэвчлэн өөрийн малаа хариулдаг хүүхдүүд байв. Гэвч хүүхдүүдийн үзэж байгаагаар цас, шороон шуурганд мал хариулах, хөрзөн ховхлох, зөөх, төл бойжуулах, өвөл морь унах, эмнэг сургах, хариулсан малаасаа дутаах явдал хамгийн хэцүү зүйл байдаг байна. Эндээс мал малладаг хүүхдүүдийн ажил хөдөлмөрийн орчин хүнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүд эрсдэлт шинжийг агуулж байгаа нь тодорхой харагдаж байлаа.

Хэдийгээр судалгаанд маш бага хувийг эзэлж байгаа ч мал хариулж явахдаа ялангуяа чонотой газраар мал хариулахаас айдаг байна. Мөн 13-аас дээш насны буюу бие даан малд явдаг хүүхдүүдийн 17.5 хувь нь малаа алдаж үрэгдүүлэх, чононд идүүлэх тохиолдол гарч байсан гэжээ. Хонь, малаа чононд идүүлж, алдаж байсан гэж хариулсан хүүхдүүдийн 14.3 хувь нь ажил олгогчдоо хонь малыг нь төлж өр төлбөрийг барагдуулж байжээ.



*Тайлбар. Чоно, нохой элбэгтэй газар миний хүү хониныхоо дэргэдээс холдож болдоггүй юм шүү гэж өвөө надад захисан.*

Судалгаагаар хүүхдийн хөдөлмөрийн аюулгүй байдал ямар байгаад бас анхаарлаа хандуулсан бөгөөд мал малладаг хүүхдүүдийн 24.2 хувь нь мал маллаж байхад эрүүл мэнд, амь насанд нь аюултай нөхцөл байдал үүсч байсан гэж хариулжээ. Чухам ямар ямар аюултай нөхцөл байдал үүсч байсныг Зураг 3.14-т харуулав.

Мал маллаж байх үед нь аюултай байдал үүсч байсан гэж хариулсан хүүхдүүдийн бараг 40 хувь нь галзуу малд довтлуулах, нохойд ноцуулах, 32.8 хувь нь байгаль, цаг агаарын гэнэтийн үзэгдэл шуурга, цас, бороо, шороон шуурганд өртөх, 19 хувь нь морь малд өшиглүүлэх, мөргүүлэх тохиолдол байсан гэсэн байна.



***Тайлбар. Салхитай хүйтэн өдөр ямаа хариулахад яггүй гэж эмээ надад дулаан хувцас бас унадаг дугуй авч өгсөн.***

• Мал маллаж байх үедээ эрүүл мэнд, амь насанд нь аюултай нөхцөл байдлуудад өртөж байсан гэж хариулсан хүүхдүүдийн 39.1 хувь нь бэртэж гэмтэж байсан гэж

хариулснаас харахад мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүүхдүүдийн хөдөлмөр эрсдэлтэй, бэртэж гэмтэх магадлалтай болох нь харагдаж байна.

Энэ асуудлыг цааш нь гүнзгийрүүлэн өөрийн ажлын талбар дээрээ ямар эрсдлүүдтэй тулгарч байсныг судалж хүснэгтээр үзүүлэв.

### **Хүснэгт 3.11. Мал малладаг хүүхдүүдийн хувьд ажлаа хийх явцад тулгарч байсан эрсдлийн төрөл, хувиар**

Хүүхдүүдийн хариултаас харахад ажлын талбар дээр ямар нэгэн эрсдэл бага гэсэн хэдий ч нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 10 хувь нь өвчтэй малтай шууд харьцаж байгаа, 16 хувь нь хутга мэстэй зүйл хэрэглэдэг, 18 хувь нь хүнд ачаа зөөдөг, 36 хувь нь хэт тоостой орчинд ажилладаг гэснээс үзвэл малчин хүүхдүүдийн зарим нь хүнд, эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгааг харуулж байгаа юм. Үүнээс гадна өмнө өгүүлсэнчлэн байгаль, цаг уурын хүнд нөхцөл, чоно нохойд ноцуулах, морь малд өшиглүүлэх зэрэг эрсдэлтэй хөдөлмөр эрхэлдэг атлаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас хэрэглэл, зааварчилгаа мэдээллээр хангагддаггүй зэргийг тооцвол малчин хүүхдийн хөдөлмөр эрсдэлт шинжийг агуулж байгаа юм.

**Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувьд өвчтэй малд тариа хийх, хамуутай мал угаах, өтсөн мал эмчлэх зэрэг химийн хортой бодистой ажиллах явдал мэр сэр байгааг** судалгааны дүн харуулж байна. Эдгээр ажлууд нь хүүхдүүдийн эрүүл мэндэд хэр зэрэг сөрөг үр дагавартай болохыг дийлэнх хүүхдүүд мэднэ, хэрхэн биеэ хамгаалах талаар ч мэднэ гэж хариулсан боловч харин хамгаалалтын хувцас, хэрэгсэл огт хэрэглэдэггүй байна. Айлын мал малладаг хүүхдүүдийн 54.9 хувь нь ажил олгогчоос хувцас өгдөггүй гэжээ.

Ажлын хувцас олгодог бол ямар ямар хувцас хэрэглэл олгодог болохыг тодруулахад малгай каска, гутал, бэлтгэлийн хувцас, дээл, бээлий зэргийг хүүхдэд өгч байжээ. Морь унадаг хүүхдүүдийн хувьд толгой тархины бэртэл гэмтлээс сэргийлж малгай заавал тавьж өгдөг болжээ.

Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 70.8 хувь нь хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар мэдээлэл зөвлөгөө авч байсан гэж хариулсан нь сайшаалтай үзүүлэлт юм. Харин ямар эх үүсвэрээс голдуу мэдээлэл авч байгааг асуухад телевиз, радиогоос гэж хариулсан бөгөөд авч байгаа мэдээллийн гол агуулга нь цаг агаарын тухай байдаг ба үйлдвэрлэлийн болон ажлын байранд үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх ур чадвар олгох явдал дутмаг байгаа нь ажиглагдав.

#### **3.3.4. Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн эрүүл ахуйн нөхцөл байдал**

Мал аж ахуйн хөдөлмөр цаг наргүй үргэлжилдэг, бэртэх гэмтэх эрсдэл өндөртэй байдаг. Гэсэн хэдий ч мал маллаж байгаа хүүхэд болон түүний эцэг эх, гэр бүл, ажил олгогч нар нь хүүхдийн эрүүл мэндэд төдийлөн анхаарал хандуулдаггүй жишээ баримтууд олон байдаг. Ялангуяа цас шуурганд өртөх буюу морь малнаас унаж нас барсан, гэмтсэн, тахир дутуу болсон тохиолдлууд нэлээд гарч байгаа билээ.

Иймд мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн эрүүл ахуйн нөхцөл байдлыг тодруулах нь судалгааны томоохон зорилтын нэг байв. Хүүхдүүдээс эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж байсан эсэхийг асуухад дийлэнх нь буюу 73.1 хувь нь хамрагдаж байсан гэж хариулсан юм. Харин хамрагдаагүй хүүхдүүдийн хувьд сум орон нутагт эрүүл мэндийн үзлэг явагддаггүй, үзүүлэх шаардлага гардаггүй гэсэн юм.

**Хүснэгт 3.12.**

**Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг судалгаанд хамрагдсан хүүхдүүд эрүүл мэндийн дэвтэртэй эсэх, байршил болон насны бүлгээр**

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн дийлэнх нь эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй байна. Харин бага насны / 9-12 насны/ хүүхдүүдийн 30 хувь нь эрүүл мэндийн даатгалын дэвтэргүй байлаа. ЭМД-ын дэвтэргүй байгаагийн шалтгааныг хүүхдүүд эмнэлэгт үзүүлдэггүй, хэрэглэдэггүй, дэвтрээ алдсан, бичиг баримт байхгүй зэргээр тодорхойлж байлаа. Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байхдаа өвдөж байсан гэж нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 15.2 хувь нь хариулсан бөгөөд чухам ямар, ямар өвчнөөр өвдөж байсныг дараахь зургаар үзүүлэв.



Судалгаанаас үзэхэд ажлын нөхцөл байдлаас шалтгаалсан өвчлөл хүүхдүүдэд илүүтэй тохиолдож байгаа ба нийт өвчлөл дотор тархи хөдлөх, даарч хөрснөөс ханиад хүрэх, бөөр, нуруу өвдөх нь зонхилж байна

**Өвдсөн хүүхдүүдийн 63 хувь нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ авдаг гэж хариулсан ч дийлэнх нь эм авч уудаг ажээ.** Харин хүүхдийн 60 хувь нь уусан эмийн зардлыг эцэг эх гаргадаг, 20 хувь нь ажил олгогч өгдөг гэсэн байна.

Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүссэн тохиодолд 39.1 хувь нь бэртэж гэмтдэг хэмээн хариулсан. (Хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдал хэсэгт) Энэ тохиолдолд өвдөж бэртсэн хүүхдүүдийн тал хувь нь л эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байжээ. Эндээс харахад хүүхэд өвдсөн болон амь нас, эрүүл мэндэд нь аюул тулгарсан тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээг хангалттай авч чадахгүй байна.

**Хүснэгт 3.13.**

**Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байхдаа гэмтэл, бэртэл авч байсан гэж хариулсан үзүүлэлтүүд**

**Кейс:** Т. А... 16 настай, эрэгтэй, 9-р ангид сурдаг, одоо сургуулийн дотуур байранд амьдардаг. Говьсүмбэр аймгийн 5-р багт ээж, хойт эцэг, 3 дүүгийн хамт амьдардаг. Тэрээр 13 настай байхдаа цагаан сараар нагац ахынхаа (ээжийнх нь дүү) хурдан морь унаж уралдах үеэр нь хөлийн жийрэг нь доошилсноор 2 хөлөө шилбээ хөлдөөжээ. Энэ хүүхэд 2 сар эмнэлэгт, дараа нь 6 сар ахындаа хэвтэж эмчлүүлсэн. Хоёр жил шахам хөл нь идээтэй явсан байна. Одоо нэг хөл бүрэн идгэрсэн. Нөгөө хөлний шарх сэдэрч магадгүй ажээ. Хүүхдийн хэлснээр хөлөө хөлдөөх үед 'надад дулаахан юм шиг санагдаж байсан, харин томчууд болохоор их хүйтэн байсан' гэсэн юм. (Жич: Хүүхдийн хоёр хөлийнх нь шилбэ хүрэнтэж сорви тогтсон байв)

(Ганцаарчилсан ярилцлагаас, Говьсүмбэр аймаг)

- Эмнэлгийн тусламж авахгүй байгаагийн шалтгааныг хүүхдүүд бариачид бариулсан, эмнэлэг хол байсан, зүгээр байж байгаад эдгэрсэн гэх зэргээр тайлбарласан байна.

Мал малладаг хүүхдүүд малаас хүнд халдах өвчин авах, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн дүрэм журам баримтлахгүй, хамгаалалтын хэрэгсэл байхгүйгээсээ болж бэртэх, гэмтэх явдал байгааг харуулж байна.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**  
**МАЛ АЖ АХУЙН ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮҮДҮҮДИЙН**  
**ЭЦЭГ, ЭХИЙН ДУНД ЯВУУЛСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН**

**4.1 Судалгаанд хамрагдсан эцэг, эхийн нийгэм, хүн ам зүйн байдал**

Мал малладаг хүүхдүүдийн эцэг эх болон асран хамгаалагч нарыг төлөөлж дийлэнхдээ аав нар нь судалгаанд хамрагдсан байна. Ам бүлийн тоо дундаж тоо 5, хамгийн бага нь 2, дээд тал нь 10 ам бүлтэй байлаа.

**Хүснэгт 4.1**

**Судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүдийн нийгэм, хүн ам зүйн байдал,  
сонгосон үзүүлэлтээр**

o

Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 75.9 хувь нь 30-49 настай буюу ид дунд насны хөдөлмөрийн чадвартай, мөн 75.4 хувь нь тусгай болон бүрэн, бүрэн бус дунд боловсролтой байсан нь малчдын нийтлэг төлөөлөл болж чадсаныг харуулна.

**4.2. Малчин эцэг, эхчүүдийн амьжиргааны эх үүсвэр**

Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 68.6 хувь нь амьжиргаагаа залгуулдаг гол эх үүсвэрийг мал аж ахуйгаас олж байгаа орлого гэж үзэж байна. Үүнээс гадна тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэл, үйлчилгээний орлогыг ч дурьдсан байна. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн малын тоог дараахь хүснэгтэнд харуулж байна.

## **Хүснэгт 4.2.**

**Мал малладаг хүүхдүүдийн эцэг, эхчүүдийн малын тоо,  
(таван төрлөөр)**

Нийт судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 60 хувь нь 200 хүртэл хонь, ямаатай өрх байна. Ялангуяа судалгаанд хамрагдсан 220 өрхийн 46.8 хувь нь үхэргүй, 39.1 хувь нь адуугүй, 88.2 хувь нь тэмээгүй байгаагаас дийлэнх өрх нь бод малгүй хүүхдээ мал аж ахуй дээр гаргасан эцэг эхийн олонхи нь ядуувтар малчид болохыг харуулж байна.

## **Хүснэгт 4.3.**

**Судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүд өрхийн амьжиргаагаа үнэлсэн байдал  
(байршлаар, хувийн жингээр)**

Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 10.5 хувь нь өрхийн мөнгөн орлогоо хүрэлцээтэй, 33.6 хувь нь дунд зэрэг, үлдсэн хувь нь буюу 55.9 хувь нь хүрэлцээгүй буюу огт хүрэлцээгүй гэжээ.

**4.3. Хүүхдүүд мал аж ахуйн хөдөлмөр эрхлэх болсон шалтгааны талаарх эцэг эхчүүдийн санаа бодол.** Эцэг эхчүүд ямар шалтгаанаар хүүхдээ сургууль завсардуулан мал маллуулахад хүрсэн гэж үзэж байгааг дараахь зурагт харуулав.

Эндээс үзэхэд хүүхдээ мал аж ахуй дээр гаргасан шалтгааны 46.2 хувь нь ядуугаасаа буюу хүн бүлгүйгээс, 49.8 хувь нь хүүхэд нь сурах дургүй, мал маллах дуртай, гэгчлэн хүүхдийн өөрийнх нь хүсэл сонирхол, эрүүл мэндийн байдлаас болсон гэж хариулсан байна. Түүнчлэн эцэг эхчүүдийн 16.3 хувь нь л сургууль завсардсан хүүхдээ буцааж суралцуулахаар хөөцөлдөж байсан гэсэн байна. Эндээс харвал эцэг эхчүүд хүүхдээ сургуульд сургахаас илүүтэйгээр малаа маллуулж ашиглахыг илүү их сонирхдог байна. Харин эцэг эхчүүдийн дийлэнх нь буюу 84.2 хувь нь хүүхдээ албан бус сургалтанд хамруулах сонирхолтой гэж хариулсан нь хүүхэддээ суурь боловсрол эзэмшүүлэх боломжтой гэж үздэгийг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 36.8 хувь нь хүүхдээ малчин болгоно, 15.3 хувь нь хүүхэд өөрөө мэднэ, үлдсэн хувь нь барилгачин, мужаан, гагнуурчин зэрэг мэргэжилтэй болгоно хэмээн үзэж байна.

#### **4.4. Мал аж ахуй дахь хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн онцлог**

**4.4.1. Хүүхдийг хэдэн наснаас мал аж ахуйн хөдөлмөрийн дадалтай болгож байна вэ?**

Хүүхдийн онцлогоос шалтгаалан хөвгүүд 5-8 настайдаа мал аж ахуйн хөдөлмөрийн дадалтай болдог гэж эцэг эхчүүдийн 72.7 хувь нь хариулсан бол 54.8 хувь нь охидыг 5-8 насанд мөн дадалтай болж эхэлдэг гэжээ. Дунджаар хөвгүүдийн хувьд МАА-н хөдөлмөрийн дадал олгож эхэлсэн нас нь эрэгтэй хүүхэд 7 байсан бол охидын хувьд 8 настайгаас эхлэж байна.

## Нэг өрхийн МАА-д ажиллаж байгаа хүүхэд, нас, хүйс, төгссөн ангиар

ᠮᠠᠠ	ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ		2 ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ		3 ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ		4 ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ ᠠᠶᠢᠨ	
	ᠠᠶᠢᠨ	ᠠᠶᠢᠨ	ᠠᠶᠢᠨ	ᠠᠶᠢᠨ	ᠠᠶᠢᠨ	ᠠᠶᠢᠨ	ᠠᠶᠢᠨ	ᠠᠶᠢᠨ
ᠠᠶᠢᠨ								
6	-	-	-	-	16.7	1	-	-
7	0.5	1	4.5	1	16.7	1	-	-
8	0.5	1	0.0	-	-	-	-	-
9	0.0	-	4.5	1	-	-	-	-
10	1.0	2	0.0	-	33.3	2	33.3	1
11	3.0	6	4.5	1	16.7	1		-
12	4.9	10	13.6	3	16.7	1	33.3	1
13	9.9	20	9.1	2	-	-	-	-
14	17.7	36	9.1	2	-	-	-	-
15	23.6	48	22.7	5	-	-	-	-
16	20.2	41	9.1	2	-	-	-	-
17	15.8	32	22.7	5	-	-	-	-
18	3.0	6	0.0	-	-	-	33.3	1
ᠠᠶᠢᠨ							-	-
ᠠᠶᠢᠨ	86.2	175	63.6	14	16.7	1	0.0	-
ᠠᠶᠢᠨ	13.8	28	36.4	8	83.3	5	100.0	3
ᠠᠶᠢᠨ								
1	13.3	16	4.8	1	16.7	1	33.3	1
2	13.8	27	14.3	3	16.7	1	-	-
3	14.3	28	23.8	5	16.7	1	66.7	2
4	14.3	21	9.5	2	16.7	1	-	-
5	6.9	29	9.5	2	16.7	1	-	-
6	7.9	14	4.8	1	-	-	-	-
7	6.9	16	9.5	2	-	-	-	-
8	3.4	14	4.8	1	-	-	-	-
9	2.0	7	0.0	-	-	-	-	-
ᠠᠶᠢᠨ	9.4	4	4.8	1	-	-	-	-
ᠠᠶᠢᠨ	7.9	19	14.3	3	16.7	1	-	-
ᠠᠶᠢᠨ	<b>100.0</b>	<b>203</b>	<b>100.0</b>	<b>21</b>	<b>100.0</b>	<b>6</b>	<b>100.0</b>	<b>3</b>

Тайлбар: Сургууль завсардаад мал маллаж байгаа 18 хүртэлх насны хүүхэд байхгүй гэж үзсэн эцэг эхчүүдийн эзлэх хувийн жинг хасч тооцов.

## 4.4.2. Айлд байж мал малладаг хүүхэд

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 69.6 хувь нь өөрийн гэртээ байж мал малладаг

бол айлд байж мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхэд 80 буюу 30.4 хувийг эзэлж байлаа. Айлд байдаг хүүхдүүд гол төлөв өвөө эмээ, авга нагацындаа байж мал малладаг байна. Энэ нь хөдөлмөрийн гэрээ хэлцэлгүй, цалин хөлсгүй ажиллахын нэг шалтгаан болдог нь тодорхой байна.

**Хүснэгт 4.5.**

### **Айлд мал маллаж байгаа хүүхдийн нас, хүйс**

Айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн бага нь 10 настай, том нь 18 настай, дундаж нас 15. Эдгээр хүүхдүүдийн дийлэнх хувийг эрэгтэй хүүхдүүд (92.1%) эзэлж байна. Ерөнхийдөө 12 болон түүнээс дээш насны хүүхдүүд илүүтэй айлд ажиллаж байлаа. Хүүхдээ яагаад айлд ажиллуулах болсныг асуухад эцэг эхчүүдийн 29.3 хувь нь ядуу учраас, 29.3 хувь нь хүүхэд өөрөө малд дуртай,, 26.7 хувь нь мал аж ахуйн ажилд суралцангаа хоол хүнсэндээ нэмэр болдог, 13.4 хувь нь айлын мал маллангаа өөрийн цөөн тооны малыг малладаг, 1.3 хувь нь гэрээсээ айлын мал малладаг хэмээн хариуллаа.

Айлд мал маллаж байгаа хүүхдүүд дунджаар 3 жил ажилладаг бөгөөд хамгийн цөөн нь нэг жил, дээд тал нь 10 жил энэхүү ажлыг хийж байна хэмээн эцэг эх нь хариулсан байна.

#### **4.4.3. Мал маллаж байгаа хүүхдүүдийн хөдөлмөрийн хөлс, ажлын нөхцөл**

Эцэг эхчүүд хүүхдийн ажлын хөлс болон ажлын нөхцөл, аюулгүй байдал, хувцсаар хангуулах зэрэг асуудлыг гэрээ хэлцлээр бараг тохирч чаддаггүй байна.

°ëèéã

õàì ðóóèào

Айлд хүүхдээрээ мал маллуулдаг эцэг эхчүүдийн ердөө 12 хувь нь бэлэн бусаар хөлс төлөхийг тохиролцдог, 20 хувь нь хүүхдэд дулаан хувцас өгөх, 10.7 хувь нь ажлын хөлсийг хэнд өгөх тухай асуудлыг, дөнгөж 5.3 хувь нь ажлын хөлс төлөх хугацааг тус тус амаар тохиролцдог гэж хариулжээ. Үүнээс үзэхэд айлд мал малладаг хүүхдүүдийн ажлын хөлс болон хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой гэрээ, хэлцэл туйлын хангалтгүй байна. Хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахад эцэг эх, ажил олгогчийн аль аль нь анхаарал хандуулдаггүй болох нь энэ талаар 100 хувь тохиролцдоггүй гэж хариулснаас харагдаж байна. Эцэг эхчүүдийн үзсэнээр хүүхдүүдэд ажил олгогч нь сар бүр мөнгөн хэлбэрээр хөлс төлдөггүй, тэр байтугай жилийн турш хөлс төлөөгүй тохиолдол түгээмэл байдаг байна.

Айлд мал малладаг хүүхдүүдийн эцэг эхчүүдийн 93.3 хувь нь хүүхдийн ажлын хөлс, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг тохирсон гэрээ хэлцэл бараг байхгүй атлаа энэ асуудлаар ямар нэг маргаан гардаггүй гэсэн нь хүүхдийн хөдөлмөрийг үнэлэхгүй байгаагийн нэг нотолгоо болж байна. Айлд хүүхэд нь мал малладаг эцэг эхчүүдийн 12 хувь нь л бэлэн мөнгөөр ажлын хөлсийг тохирдог гэж хариулсан билээ. Энэ тохиолдолд бог мал хариулгын хөлсийг ямар ханштай байгааг тодруулахад ихэвчлэн ажил олгогч айлын үзэмжээр тохирдог гээд цөөн тохиолдолд сардаа нэг хонь, 100-200 төгрөгөөр гэх мэтээр тооцох явдал байдаг хэмээж байв.

#### **4.4.4. Хүүхдийн ажил амралтын цаг**

Мал малладаг хүүхдүүд зун, өвлийн улиралд хэдэн цагаас ажлаа эхэлж, хэдэн цагт дуусгадгийг судалсан дүнг эцэг эхчүүдийн хариулснаар дараахь бүдүүвч зургаар харуулж байна.

Мал малладаг хүүхдүүдийн хувьд хоногт ажиллах цаг зуны улиралд уртсаж, өвөл богиносгох хандлагатай байна (Хүснэгт 4.8)

Зуны улиралд хүүхдүүд өглөөний 7 цагт босч ажилдаа гардаг бол өвөл 8-9 цагийн хооронд босч ажилдаа гардаг байна. Зуны улиралд ойролцоогоор 21 цагт, өвлийн улиралд 19 цагт ажлаа дуусгаж байна. Үүнээс үзэхэд зуны улиралд хүүхэд 12-14 цаг, өвлийн улиралд 8-10 цаг ажилладаг байна. Үүнийг давхар батлах үзүүлэлт бол судалгаагаар хүүхдийн эцэг эхчүүдээс “Танай хүүхэд өдөрт хэдэн цаг ажилладаг вэ?” гэж асуухад дийлэнх нь буюу 61,0 хувь нь 9-12 цаг ажилладаг гэж хариулсан билээ.

Мал малладаг хүүхдүүдийн гол амардаг баяр нь шинэ жил, цагаан сар гэж эцэг эхчүүдийн 60 гаруй хувь нь хариулжээ. Түүнчлэн Бямба, Ням гаригуудад хүүхдүүд амрахгүй ажилладаг хэмээн бүх эцэг эхчүүд хариулсан байна.

Насанд хүрээгүй хүүхдээр хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид хүүхдийг уртасгасан

цагаар ажиллуулж байгаа төдийгүй илүү цаг ажилласан, амралтын өдрүүдэд ажилласны хөлс урамшуулал ч өгдөггүй байна.

Айлд мал маллаж байгаа хүүхэдэд тухайн айл нь хоол хүнсээр хангадагийн зэрэгцээ хөдөлмөр эрхэлж байх үеийн амьдралын нөхцөлийг эцэг эхчүүд ерөнхийдөө сайн гэж үнэлсэн болно. Мал маллаж байх үедээ хүүхэд ажил олгогчийн малыг нь дутаах, чоно нохойд бариулах явдал цөөн байдаг ба хааяа мал алдаж үрэгдүүлсэн тохиолдолд төлүүлдөг гэж эцэг эхчүүд хариулж байсан.

#### **4.4.5. Мал аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөрийн ялгаа**

Мал аж ахуйн салбарт хүүхдээр хийлгэж болох хөдөлмөрийн төрлүүдийн талаар эцэг эхчүүдийн санал ямар байгааг 18 үзүүлэлтээр судалж үзснийг зураг 4.4 –д харуулав.

Эцэг эхчүүд мал угаах, эмнэг сургах, мал нядлахаас бусад тохиолдолд МАА-н үйлдвэрлэлийн ихэнх ажлуудыг хүүхдээр хийлгэж болно гэжээ. Ялангуяа мал хариулах, аргал түлш бэлтгэх, хашаа хороо цэвэрлэх, төл бойжуулах, мал тэжээх, ус авах, мал услах, ямаа самнах, хөрзөн ховлох, ноос ноолуур авах, өвс хадлан бэлтгэх, мал саах ажлуудыг хүүхдийн хийх ажил гэж дийлэнх эцэг эхчүүд үзэж байна. Айлд хүүхдээ мал маллуулж байгаа эцэг эхчүүдийн 77.3 хувь нь хүүхэд мал малласнаар идэх хоол, өмсөх хувцастай болж гэр бүлийн орлогод нэмэр болдог гэж хариулж байлаа.



*Тайлбар. Хонь, ямаа хариулах гэдэг хүүхдийн хийх гол хөдөлмөр гэж томчууд үздэг.*

## Хүүхдээр айлын мал маллуулахын давуу болон сул тал

Эцэг эхчүүдийн талаас илүү хувь нь хүүхэддээ ямар нэг бэрхшээл тохиолддоггүй гэж үзэж байна. Бэрхшээл тохиолддог гэсэн эцэг эхчүүдийн хувьд хүүхэд даарч хөрдөг, ядардаг, хүүхэд мал маллах нь сургуулиас хөндийрч боловсрол нь орхигддог зэрэг сөрөг талтай гэж үзэж байгаа нь илүүтэй байлаа.

Түүнчлэн эцэг, эхчүүд айлын мал малладаг хүүхэд болон ажил олгогч хоёрын хоорондын харилцааг сайн байдаг, ажлын байранд хүүхдийг ажил олгогчийн зүгээс дарамтлах, хүчирхийлэх явдал бараг гардаггүй. Цөөн тохиолдолд ажил олгогчийн зүгээс ялангуяа гэрийн эзэгтэй нь хүүхдийг загнадаг, үглэдэг тохиолдол байдаг гэсэн билээ.

### **4.5. Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал**

Эцэг эхчүүдийн 73.6 хувь нь хүүхдээ эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг гэсэн бөгөөд **78.6 хувь нь хүүхдийнхээ биеийн эрүүл мэндийн байдлыг хэвийн гэж үнэлсэн** бол үлдсэн хувь нь ямар нэг суурь өвчтэй гэж үзэж байна.

**Эцэг эхчүүдийн 56 хувь нь мал маллаж байгаа хүүхдүүдэд ямар нэгэн өвчин тохиолдож байдаг гэсний дотор 19 хувь нь бруцеллёзоор өвчлөх, 31 хувь нь даарч**

хөрснөөс болж ханиад хүрэх, хоолой, бөөр нь өвчлөх, 6 хувь нь бэртэж гэмтэх тохиолдол байдаг гэж хариулжээ. Үүнээс МАА-н хөдөлмөр хүүхдийн эрүүл мэндэд тодорхой хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлж байгаа нь харагдаж байна.

Гэтэл эцэг эхчүүд хүүхдийн эрүүл мэндэд төдийлэн анхаарал тавьдаггүйгээс малаас хүнд халдварлах өвчнөөр хүүхэд өвчлөх тохиолдол байсаар байна. Хүүхэд мал дээр ажиллах явцад амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл байдал үүсч байсан эсэхийг асуухад судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 18.2 хувь нь хүлээн зөвшөөрч байгаа юм. Энэ бол бага тоо биш, анхаарал татсан асуудал гэдгийг илтгэж байна.

Хүүхдийн амь насанд аюултай байдал үүсэх тохиолдол байдаг гэж хариулсан эцэг эхчүүдийн 48.8 хувь нь байгаль, цаг уурын гэнэтийн үзэгдэлд өртөх, 25.6 хувь нь хэт халуун, хүйтэн орчинд ажиллах, 23.3 хувь нь хэт хүнд ачаа зөөх, үүрэх, татах, 20.9 хувь нь төөрөх, 16.3 хувь нь зэрлэг чоно нохой, галзуу мал амьтанд дайруулах, ноцуулах, 9.3 хувь нь өвчтэй малтай харьцах, 7 хувь нь хутга мэсийн зүйлтэй харьцах, 2.3 хувь нь хортой бодистой харьцах зэрэг шалтгааны улмаас хүүхэд аюултай байдалд өртөхөд хүрдэг гэсэн байна.

Судалгаанаас үзэхэд ихэвчлэн хүүхдүүд морь малаас унаж бэртэх, цас шуурганд гэрээсээ төөрч даарч хөлдөх зэрэг тохиолдолууд нэлээд гардаг байна. Хүүхдийн амь нас, эрүүл мэнд аюултай нөхцөл байдалд өртөж байсан тохиолдолд хүүхэддээ эмнэлгийн тусламж үзүүлсэн эсэхийг асуухад 40.9 хувь нь авч байсан, 59.1 хувь нь эмнэлгийн тусламж авч байгаагүй байна. Яагаад тусламж аваагүйгээ бариачид бариулсан, ламд үзүүлсэн, гэмтэж бэртээгүй байсан зэрэг шалтгаанаар тайлбарлажээ.

## нᠠᠶ

ᠠᠶᠢ ᠳᠦᠭᠡ ᠠᠠᠨᠠᠭᠢ

ᠠᠶᠢᠳᠠᠨᠠᠶᠢ

Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 70 гаруй хувь нь хөдөлмөрийн аюулгүй байдал, ялангуяа цаг агаарын аюулаас урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг голдуу радио, телевиз, сонин хэвлэлээр авдаг байна. Харин хүүхдийн хөдөлмөрийн тухай эцэг эхчүүдийн мэдлэг хангалтгүй байгаа нь энэ талаар ямар нэгэн мэдээлэл зөвлөгөө авдаггүй гэж 76.8 хувь нь хариулснаас харагдаж байна. Мөн эцэг эхчүүдийн 66 хувь нь хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлаар ямар нэгэн санал байхгүй буюу мэдэхгүй гэж хариулж байна.

Санал байна гэсэн эцэг эхчүүдийн хувьд багцалж үзвэл хоёр үндсэн чиглэлээр санал тавьж байна. **Нэгдүгээрт** хүүхдийн боловсролтой холбогдуулан дахин сургах, АББС-д хамруулах, мал маллаж байгаа хүүхдэд зориулсан ном хэвлэлээр хангах асуудлыг чухалчлан үзсэн бол **хоёрдугаарт** мал маллаж байгаа хүүхдүүдийн хөдөлмөрийн нөхцөл байдал, гэрээний асуудлыг хөндөж тавилаа. Үүнд: хүүхдийн ажлын хөлсийг сар бүр мөнгөн хэлбэрээр олгох, хүүхдийн хөдөлмөрийг үнэгүйгээр ажиллах явдлыг зогсоох, мал маллаж байгаа хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалсан хууль тогтоомж хэрэгтэй гэсэн саналуудыг дэвшүүлж байлаа.

Түүнчлэн МАА дахь хүүхдийн хөдөлмөр, ялангуяа осол бэртэл, өвчлөлийн талаар телевиз, радио болон хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр ухуулга сурталчилгаа явуулах, малаас хүнд халддаг өвчлөл болон осол бэртлээс сэргийлэх ажил зохион байгуулахыг илүүтэй санал болголоо. Мөн эцэг эхчүүдийн 42.8 хувь нь энэ талаар сайн хэлж мэдэхгүй байна гэсэн нь томоохон байр суурь эзэлж байна.

Хүүхдээр мал аж ахуйн хөдөлмөр эрхлүүлэх явдлыг судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн дийлэнх нь хүлээн зөвшөөрч байгаа атлаа хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал зэрэг чухал асуудлыг төдийлөн анзаардаггүй, анхаарал тавьдаггүй болох нь судалгаанаас ажиглагдаж байна.

## **ТАВ. МАЛ АЖ АХУЙН ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮҮХДҮҮДИЙН АЖИЛ ОЛГОГЧДЫН ДУНД ЯВУУЛСАН СУДАЛГААНЫ ДҮН**

---

Энэ хэсэгт МАА-д ажиллаж байгаа хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар ажил олгогч нарын дунд явуулсан судалгааны дүнг танилцуулна. Төрсөн гэрээсээ өөр төрөл садангийн болон бусад айлд байж мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийг ажиллуулж байгаа өрхийг ажил олгогч гэж үзэж энэ судалгаанд хамруулав.

### **5.1 Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын нийгэм, хүн ам зүйн байдал**

Энэхүү судалгаанд нийт ажил олгогч 57 хүн хамрагдсан ба ажил олгогчдын нийгэм, хүн ам зүйн байдлыг дараахь хүснэгтэнд харуулав.

**Хүснэгт 5.1**

#### **Судалгаанд хамрагдсан ажил олгогч нарын нийгэм, хүн ам зүйн байдал**

o

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 80 гаруй хувь нь эрэгтэйчүүд юм. Бүрэн дунд боловсролтой хүмүүсийн эзлэх хувийн жин өндөр байлаа. Судалгаанд хамрагдсан 57 ажил олгогчоос 52 нь тэмээнээс бусад 4 төрлийн малтай байна. Малын дийлэнх нь бог мал бөгөөд ажил олгогч нэг өрхөд дунжаар 257 хонь, 174 ямаа, 33 үхэр, 39 адуу ногдож байна.

### **5.2 Айлд мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн талаарх ерөнхий мэдээлэл**

Судалгаанд хамрагдсан нийт ажил олгогчид бүгд өөр айлын нэг хүүхдийг мал аж ахуй дээрээ ажиллуулдаг байна.

**Ажил олгогчийнд мал маллаж байгаа хүүхдийн нас, хүйс**

Айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн 84.2 хувь нь 14-өөс дээш насны, мөн тэдний 91.2 хувь нь эрэгтэй хүүхдүүд байгаагаас үзвэл ажил олгогчид аль болохоор ахлах насны хөвгүүдийг ажиллуулахыг илүү сонирхдог байна. Ажил олгогчийнд хүүхдүүдийн ажилласан хугацааг сараар тооцож харуулахад хамгийн бага нь 2 сар ажилласан байхад дээд тал нь 120 сар буюу 10 жил ажилласан байна. Айлд ажиллаж байгаа хүүхдийн дундаж нас 14, ажилласан дундаж хугацаа 24 сар байна. Ажил олгогчийнд ажиллаж байгаа хүүхдүүдийн 61.4 хувь нь хамаатан садны хүүхэд, 38.6 хувь нь өөр айлын хүүхэд гэж хариулснаас үзвэл ажил олгогчид хамаатан садны хүүхдүүдийг мал аж ахуйд ажиллуулах явдал дийлэнх байгааг харуулж байна.

Ажил олгогчдын 42.1 хувь нь тухайн хүүхдэд өөрөө санал тавьж малаа малуулах болсон гэсэн нь нийт хариултуудын дийлэнх хувийг эзэлж байлаа. Үлдсэн 26.3 хувь нь хүүхэд өөрөө ирсэн, 28.1 хувь нь эцэг эх нь санал болгосон, 3.5 хувь нь найз нөхөд, хамаатан садан санал болгосон гэх зэргээр хариулжээ. Эндээс харвал ажил олгогчид өөрсдөө санал болгох, хүүхдийн эцэг эх нь санал тавих ийм хоёр хэлбэрээр хүүхэд ажиллуулдаг нь зонхилж байна.

**Ажиллаж буй хүүхдүүдийн боловсролын байдлыг авч үзвэл 57.9 хувь нь бага, 14 хувь нь суурь, 28 хувь нь огт боловсролгүй гэж ажил олгогчид хариулснаас харвал айлд мал маллаж байгаа хүүхдүүд бага эсвэл огт бовсролгүй байна.**

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 40 хувь нь мал маллаж байгаа хүүхдийн боловсролыг дээшлүүлэх талаар ямар нэгэн санал санаачлага гаргаж байгаагүй гэж хариулжээ. Энэ нь судалгаанд хамрагдсан хүүхэд, эцэг эх, ажил олгогчдын аль аль нь хүүхдийн боловсрол, ирээдүйд анхаарал тавьдаггүй болохыг харуулж байна.

### **5.3 МАА дэхь хүүхдүүдийн хөдөлмөр**

#### **5.3.1 Хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл**

Ажил олгогчдын хариулснаар хүүхдүүдийн 75 хувийг тэд гэртээ байлгаж малаа маллуулдаг байна. Хүүхдийн өөрсдийн гэр нь ажил олгогчийнхоос дунджаар 42 км-ийн зайтай байдаг байна. Гэвч зарим хүүхдүүдийн гэр ажил олгогчийнхоос нэг км хүрэхгүй ойрхон оршдог бол 420 км хол гэртэй хүүхдүүд ч байдаг ажээ. Мөн ажил олгогчийнд амьдардаггүй хүүхдүүдийн хувьд өөрийн гэрээсээ явж ажил олгогчийн малыг малладаг, өвөө эмээгийн дээ байж малыг нь малладаг гэжээ.

- **Ажил олгогчдын 91.2 хувь нь улирлын онцлогт тохируулан хүүхдэд хувцас авч өгдөгийн дээр өдөрт 2-3 удаа хооллодог гэжээ.** Нийт ажил олгогчдын 56.1 хувь нь хүүхдийн зүгээс ямар нэгэн хүсэлт гаргаж байгаагүй, харин хүүхдүүдээс санал хүсэлт тавьж байсан гэж ажил олгогчдын хариултыг нэгтгэж хүснэгт 5.4-д харуулав.

#### **Хүснэгт 5.4.**

#### **Ажил олгогчдод хүүхдийн зүгээс тавьж байсан хүсэлт, хувийн жингээр**

Ажил олгогчдын 30 шахам хувь нь хүүхэд гэр уруугаа явах зөвшөөрөл хүсэх, ажлын хувцас хэрэглэлээр хангахтай холбоотой хүсэлт гаргаж байсан гэжээ. Хэдийгээр цөөн хувийг эзэлж байгаа ч хүүхэд цалин хөлс, ажлын нөхцөлтэй холбоотой хүсэлтүүдийг ажил олгогчдоо санал болгож байжээ.

Ажил олгогчийн хэлснээр хүүхдээр дараахь төрлийн МАА-н хөдөлмөрийг хийлгэж байна. (Зураг)

**МАН-н салбарт мал хариулах, төл бойжуулах, ус авах, мал услах зэрэг олон төрлийн ажлыг хүүхдээр хийж гүйцэтгүүлж байгаа нь** судалгаанаас харагдаж байна. Хэдийгээр цөөн хувьтай илэрч байгаа ч хүүхдээр мал угаалгах, мал нядлуулах зэрэг хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай хөдөлмөрийн төрлийг хийлгэж байна. Үүнээс гадна эмнэг сургах, хурдны морь унах зэрэг хүүхдийн тэвчишгүй хүнд хөдөлмөрийн жагсаалтанд орсон хөдөлмөрийг хүүхэд хийж байна.

Дээр дурьдсан ажлуудаас хүүхдийн нас, биед ахадсан хүнд хөдөлмөр байна уу гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 56.1 хувь нь хүүхдэд ахадсан хүнд ажил хөдөлмөр байхгүй гэж хариулсан. Харин үлдсэн хувь нь мал эрэх хайх, мал нядлах, мал угаах зэрэг нь хүүхдэд ахадсан ажил гэсэн билээ. Эндээс харахад ажил олгогчид хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, эрүүл мэнд, амь насанд нь аюултай хөдөлмөр эрхлүүлж байгаагаа төдийлөн ойлгохгүй байгаа, энэ талын мэдлэг мэдээлэл хангалтгүй байгааг харуулж байна.

### **5.3.2 МАН-н хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн хөдөлмөрийн хөлс, нөхцөл**

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 81 хувь нь хүүхэд ажиллуулахдаа эцэг, эх эсвэл хүүхэдтэй өөрсөдтэй нь аман хэлцэл хийсэн, 16 хувь нь огт гэрээ, хэлцэл хийгээгүй гэжээ. (Зураг 5,3)

Ажил олгогчдын хоёр нь буюу дөнгөж 3 хувь нь эцэг эх, харгалзан дэмжигчидтэй нь бичгээр гэрээ хийсэн гэжээ. **Өөрөөр хэлбэл МАА-н салбарт хүүхдийг ажиллуулахдаа албан ёсны хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилладаггүй болох нь хүүхэд, эцэг эх, ажил олгогч нарыг хамруулан явуулсан судалгааны дүнгээс харагдаж байна.** Ажил олгогчдын 43.9 хувь нь цалин хөлсний хэмжээ, өгөх хэлбэрийг тохирдог, 56.1 хувь нь ямар нэг тохиролцоо хийдэггүй гэж, хариулсан байна. Судалгааны дүнгээс үзэхэд хөдөлмөрийн гэрээний нөхцөлд боловсролын талаар ямар ч асуудал тусгагддаггүй байна. Түүнчлэн ажил амралтын цаг, ажлын төрөл, давтамж, аюул осол гэмтлээс урьдчилан сэргийлэх асуудал үндсэндээ орхигддог гэж хэлж болохоор байна.

**Ажил олгогчид 29.8 хувь нь ажлын хөлсийг бэлэн мөнгөөр, 70.2 хувь нь мөнгөн бус хэлбэрээр олгодог гэж хариулж байна.** Бэлэн мөнгөөр олгодог гэж хариулсан ажил олгогчдын хувьд хамгийн бага нь сард дунджаар 40,0 мянган төгрөг өгдөг гэсэн бол дээд тал нь 120,000 төгрөг өгдөг гэжээ. Мөнгөн бус хэлбэрээр урамшуулал өгдөг гэж хариулсан ажил олгогчдын дийлэнх нь хоол, хувцас авч өгдөг гэж хариулсан бол цөөн тохиолдолд хичээлийн хэрэглэл авч өгдөг гэсэн билээ.

Ажил олгогчдын хувьд малаа маллуулж байгаа хүүхдээ хувцаслах, хоол хүнс өгөх, жилдээ 1-2 удаа ганц нэг мал өгөх зэргээр хүүхдийн хөдөлмөрийн хөлсийг төлж байгаа байдал нийтлэг ажиглагдаж байна. Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын дөнгөж 24.6 хувь нь сар бүр хүүхдийн ажлын хөлс, урамшууллыг олгодог гэснээс Хөдөлмөрийн хуулийн тухайн заалтыг бараг хэрэгжүүлдэггүй болох нь харагдаж байна. Гэтэл хөлс урамшууллын талаар ямар нэгэн маргаан гарч байгаагүй гэж ажил олгогчдын дийлэнх хариулж байгаа нь сонирхол татаж байлаа. Энэ нь ажил олгогчид гэж үзэж бидний судалгаандаа хамруулсан өрхийн олонхи нь тухайн айлд мал маллаж байгаа хүүхдийн өвөө, эмээ, авга нагац зэрэг ах дүү нар нь байдагтай холбоотой.

*Кейс:*

*Хэнтий аймгийн Мөрөн сумын малчин Ц. 68 настай. Ач хүү Г.-ыгаа 5-р ангиас нь гаргаж гэртээ авчран гэрээ хэлцэлгүй мал аж ахуйн хөдөлмөр эрхлүүлж байгаагийн учир шалтгааныг тайлбарлахдаа- “ Бид чинь үе улиран мал маллаж өссөн улс. Гэтэл малчдын залгамж халаа цөөрч мал маллах хүнгүй болох нь. Хөдөөгийн бидний хүүхдүүд чинь дунд сургууль л төгсвөл хот суурин уруу алга болж байна. Ингээд байвал энэ малыг хэн маллах вэ. Хүүхдийг малчин болгоё гэвэл аль болох багаас нь мал маллагааны дадалтай болгох хэрэгтэй байдаг юм. Миний энэ ач хүү малд гярай, малчны ажилд их сонирхолтой. Тэгээд л би өөр дээрээ авсан юм. Малчны хүүхэд дор хаяж хотын хүүхдийг бодвол өглөө эрт босно, орой аажуу унтана. Авхаалжтай сэргэлэн, хөдөлмөрч, залхуугүй байдаг. Би ач хүүгээ өсгөж хүмүүжүүлж, хөдөлмөрт үнэ төлбөргүй сургаж, хооллож, хувцаслаж, хэрэгцээтэй үед нь мөнгө төгрөгөөр урамшуулж байна. Юу нь болохгүй гэж. Хотын та нар чинь барилга, оёдолчин, мужааны дамжаанд сурсан ч төлбөр нэхдэг гээ биз дээ.. Бид тэгэхгүй. харин ч цэрэгт яваад ирэхээр нь мал таслан өгч гэрлүүлнэ*

*(Ганцаарчилсан ярилцлага, Хэнтий аймаг Мөрөн сумын малчин, 68 настай, эрэгтэй)*

Иймэрхүү тайлбарыг хүүхэд ажиллуулж байгаа өвөө, эмээ, авга, нагац зэрэг хамаатан садны холбоотой ажил олгогч нар олонтаа дурьдаж байсан

Ажил олгогчид хүүхэд өглөө 6-10 цагийн хооронд ажлаа эхэлж, орой 16-23 цагийн хооронд ажил дуусдаг гэж үзэж байна. Хүүхэд өдөрт дор хаяж 10 цаг ажиллах нь ердийн хэрэг гэж байгаагаас үзвэл ажлын ачаалал их, олон цагаар ажиллаж байгааг илтгэж байлаа. Хүүхдүүд ихэнхдээ ажил олгогчийндоо цайгаа уудаг хэмээн ажил олгогч үзэж байна. Мөн наадам, цагаан сар, шинэ жил зэрэг баяраар амардаг гэж хариулсан байна. Хүүхэд ажил олгогчийнд уртасгасан цагаар, амралтгүйгээр ажиллаж байгааг судалгаанд хамрагдсан хүүхэд, эцэг эхчүүд ч баталгаажуулж байсан юм.

#### **5.4 МАА-н ажил эрхэлж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн аюулгүй байдал**

Ажил олгогчдын 54.4 хувь нь мал маллаж байгаа хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байсан гэж хариуллаа. Тэдний ярьж байгаагаар мал малладаг хүүхдүүдийн дийлэнх нь эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй байна.. Энэ нь 16 нас хүртэлх хүүхдийн эрүүл мэндийн

даатгалыг төр хариуцаж, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд үнэ төлбөргүй хамруулж байгаатай холбоотой юм. Харин мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд тогтмол эрүүл мэндийн үзлэгт хамруулж байсан эсэхийг тодруулахад 40.1 хувь нь мэдэхгүй, эсвэл үгүй гэсэн бол, 24.6 хувь нь жилд нэг удаа, 21.1 хувь нь хагас жилд нэг удаа, үлдсэн хувь нь морь малнаас унасан үед үзүүлдэг гэсэн байна.

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 66.7 хувь нь хүүхэд ямар өвчнөөр өвддөгийг мэдэхгүй, ер нь өвддөөд байдаггүй гэсэн бол гуравны нэг нь мал маллаж байхдаа хүүхэд даарч хөрсний улмаас ханиад хүрэх, морь малнаас унаж тархи хөдлөх, толгой нь өвдөх тохиолдлууд гардаг гэжээ. Малаас хүнд халддаг бруцеллез өвчтэй хүүхэд байдаг гэж 8.8 хувь нь, ямар нэг архаг хууч өвчтэй байдаг гэж 7 хувь нь хариулсан байна.

Ажил олгогчид бүгд хүүхэд мал маллаж байх үед тэдний амь нас, эрүүл мэндэд ноцтой хор хохирол учруулахуйц аюултай нөхцөл байдал үүсч байгаагүй гэж хариулсан байна. Харин мал аж ахуйн салбарт ажилладаг хүүхдүүдэд морьноос унаж тархи нь хөдлөх, моринд өшиглүүлэх, хазуулах, үхэр, тэмээнд тийрүүлэх зэргээр арьс зулгарах, хөл гараа гэмтээх, цасан шуурганд өртөж нүүр, гар хөлөө хөлдөөх, осгох, төөрөх зэргээр бэртэж гэмтэх тохиолдол ховор боловч байдаг гэжээ.

Өвлийн цагт морин уралдааныг зохион байгуулах нь хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн нэг төрөл гэж үздэг. Энэ талаар ажил олгогчид ямархуу саналтай байгааг тодруулахад 38.6 хувь нь морин уралдааныг дэмжиж байна, 61.4 хувь дэмжихгүй байна гэсэн билээ.

Нийт судалгаанд оролцогч ажил олгогчдын 59.6 хувь нь хүүхдэд ямар нэгэн ажлын хувцас олгодог гэж хариуллаа.

Дийлэнх ажил олгогчдын хувьд хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх мэдээллийг телевиз, радиогоос авдаг байна. Мал аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар ямар нэгэн санал байгаа эсэхийг судлахад 61.4 хувь нь ямар нэгэн санал байхгүй хэмээн хариуллаа. Санал байна гэж хариулагчдын хувьд хүүхдийг албан бус сургалтанд хамруулах, гэрээр ном уншуулахад анхаарах зэрэг саналуудыг тавьж байсан болно. Судалгаанд хамрагдсан ажил олгогч, эцэг эхчүүдийн аль аль нь мал аж ахуйд хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар ямар нэгэн санал байхгүй гэж үзэж байв.

### **ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

1. “Мал аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл” судалгааг ОУХБ –аар баталгаажсан арга зүйн дагуу, монгол орны байгаль, газар зүй, эдийн засгийн бүс нутгийн төлөөлөлийг үндсэнд нь хамруулж гүйцэтгэв. Судалгаанд 7 аймгийн 32 сумын малчин өрх 220, ажил олгогч 57, мал аж ахуйд ажиллаж буй 263 хүүхэд хамрагдснаар мал аж ахуйн хөдөлмөр эрхлэж байгаа хүүхдийн хөдөлмөр, ахуйн нөхцөл, эрсдэл, тэдний боловсрол, эрүүл мэндийн талаар нэгдсэн ойлголт, дүгнэлтэд хүрэх боломжийг олгов.

2. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 77.2 % нь эрэгтэй байгаагийн зэрэгцээ 15-18 насны хүүхдийн эзлэх хувийн жин өндөр / 62.7 % / байна. Хөдөөд хөвгүүдийг сургууль завсардуулж боловсролоос хөндийрүүлэх хандлага давамгайлж байна.

3. Мал хариулах, аргал түлш бэлтгэх, хашаа хороо цэвэрлэх, төл бойжуулах, мал услах, тэжээх, ямаа самнах, хөрзөн ховхлох зэрэг 15 төрлийн ажлыг эцэг эхчүүдийн 50-иас дээш хувь нь хүүхдээр хийлгэж болно гэж үзсэн байна. Харин мал угаах, нядлах, хурдан морь унах зэрэг хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт болгоомжтой хандах ёстой гэжээ.

4. Малчдын хүүхдүүдийн МАА ажилд анх оролцож эхлэх нас 6, бие дааж мал маллах дундаж нас 10 байна. Эдгээр нас нь үндэсний уламжлалын үүднээс хүлээн зөвшөөрч болох боловч хүүхдийн хөдөлмөрийн хэм хэмжээний талаар олон улсын тавигдаж байгаа шаардлагатай зөрчилдөж байна. Тухайлбал ОУХБ-ын 138 дугаар Конвенцийн дагуу буурай хөгжилтэй орнуудад хүүхэд хөнгөн ажил эрхлэх насны доод хязгаарыг 15 гэж тогтоосонтой зөрчилдөж байна.

5. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 30.4 % төрсөн гэрээсээ өөр газар мал маллаж байгаагийн дотор 13.4 % нь ажил олгогчийнд ажиллаж байна. Тэдний дотор 10 жил хүртэл хугацаагаар айлд хөлслөгдөж байгаа хүүхэд ч байна. Өөрийн гэрээс бусад газар мал маллах нь далд хэлбэрээр хүүхдийн хөдөлмөрийг ашиглах, үндсэн эрхүүдийг зөрчих нөхцөл байж болохоор байна.

6. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн олонхи нь 9-12, түүнээс дээш цагаар ажилладаг гэж хариулсан төдийгүй насны бүлэг дээшлэх тусам ажиллах цаг уртасч байна. Тухайдбал, 13-14 насныхны 43.3 % нь, 15-18 насныхны 50 хувь нь хоногт 9-12 цагаар, нийт хүүхдийн 6.8 % нь хоногт 13, түүнээс дээш цагаар ажиллаж байна. Хоногийн ажлын цаг нь хүүхдийн нас, бүс нутгийн байршлаас хамаарч харилцан адилгүй байгаа хэдий ч ямар ч тохиолдолд 7 хоногт 24-өөс илүү цаг МАА-н ажилд зарцуулдаг болох нь судалгаагаар тодорхойлогдсон болно.

7. Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн 45 % нь цалин, хөлсний хэмжээг аман хэлбэрээр тохирдог гэсэн боловч хөдөлмөрийн харилцааны бусад нөхцөл болох ажил, амралтын цаг, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, осол гэмтлийн үед олгох нөхөн төлбөр, ажлын төрөл, ачаалал, давтамжийн талаар ямар нэг тохиролцоо байхгүй гэж 100 % хариулсан байна. Хүүхэд, эцэг эхийн эдийн засгийн сонирхлыг үндэслэн нэг талын давуу эрхтэй хийгддэг энэхүү тохиролцоо нь албан ёсны гэрээ хэлцэл бус учраас эцсийн дүндээ хүүхдийн сурч боловсрох, эрүүл байх, хөгжих үндсэн эрхүүдийг зөрчиж улмаар эрүүл мэнд, амь насанд сөрөг үр дагавар учруулахыг үгүйсгэх аргагүй юм.

8. Өөрийн гэрээс бусад айлд мал маллаж буй хүүхдийн 30% нь мөнгөөр, үлдсэн хувь нь хоол хүнс, хувцас, хичээлийн хэрэгсэлийн хэлбэрээр ажлын хөлсөө авдаг гэсэн боловч цалин хөлсний хэмжээ маш доогуур байна. Айлд хөлсөөр ажиллаж байгаа хүүхэд сард

дунджаар 53,0 мян төг авдаг нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэн хагаст ч хүрэхгүй байгаагийн дээр зарим нь сард 1000 хүрэхгүй төгрөг гар дээрээ авсан гэж хариулсан. Хүүхдэд ажлын хөлсийг тогтмол бус /30.9 %-д сар бүр, 27.2%-д жилд, 27.2% улиралд тус бүр нэг удаа / олгож байна.

9. Гэр нь алс хол тул хүүхэд ажил олгогчдын гэрт байнга амьдрах явдал нийтлэг байна. Хүүхдийн гэр ажил олгогчийнхоос дунджаар 42 км зайтай байдгаас айлд мал малладаг хүүхдийн 75% ажил олгогчийнд байдаг байна. Ажил олгогчдын 91.2 % улирлын онцлогоор хүүхдийг хувцаслаж, өдөрт 2-3 удаа хооллодог, 70 % нь хүүхдийн зүгээс ямар нэг хүсэлт гаргаж байгаагүй гэсэн зэрэг нь дээрх дүгнэлтийн нотолгоо болно. Өвлийн цагт морин уралдаан зохион байгуулахыг ажил олгогчдын 61.4 % дэмжихгүй байна.

10. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд ихэвчлэн өглөө 7 цагт босч, 22 цагт унтдаг гэж хариулснаас үзэхэд тэд уртасгасан цагаар ажилладаг болох нь тодорхой юм. Тэдний 42.2 % нь тэмдэглэлт баярын өдрөөр амардаггүй ажээ. Дээрхи мэдээлэл нь малчин хүүхдүүдийн хувьд ажлын 1 өдрөөс дараагийнх хүртэл амрах хугацаа Хөдөлмөрийн хуулиар тогтоосон доод хугацаа болох 12 цагаас бага байгаа, нийтээр амрах баяр ёслол, амралтын өдрүүдэд амрах боломжгүй зэрэг нь хэдийгээр үйлдвэрлэлийн онцлогтой холбоотой боловч хөдөлмөрийн харилцааны үндсэн хэм хэмжээг зөрчиж байгааг харуулж байна.

11. Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 24.2 % нь эрүүл мэнд, амь насанд аюултай нөхцөл байдал үүсч байсан гэсний дотор галзуу мал, нохой довтлох /40%/ , байгаль, цаг агаарын гэнэтийн үзэгдэл цас, шороон шуурганд өртөх, малаа алдах, өлсөх, даарах, айх, ядрах /32.8%/ , морь малд өшиглүүлэх, мөргүүлэх /19%/ зэрэг бэрхшээлтэй тулгардаг байна. Тэдгээрийн 6.8 % нь эцэг эх, ажил олгогчдоо загнуулах, зодуулах зэргээр ямар нэг дарамт амсдаг байна.

12. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ажлын байран дахь эрсдэлүүдийн дотор хэт тоостой орчинд /36%/ ажиллах, хэт хүнд ачаа өргөх, зөөх /18%/ , хутга мэстэй харьцах /16.8%/ , өвчтэй малтай харьцах /10%/ тохиолдол байна. Аюултай нөхцөл байдалд өртсөн хүүхдүүдийн 39.1 % нь ямар нэг хэмжээгээр бэртэж гэмтэж байжээ.

13. Нийт хүүхдийн 70.8 % нь телевиз, радиогоор хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар мэдээлэл авдаг гэсэн боловч харамсалтай нь зонхилох мэдээлэл нь цаг агаарын мэдээллээр хязгаарлагдаж байна. Ажлын ба үйлдвэрлэлийн орчны аюулгүй ажиллагааг хангах мэдлэг, ур чадвар дутмаг байна.

14. Хүүхдүүдийн 73.1 % эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг байна. Гэвч 9-12 насны хүүхдийн 30 % нь эмнэлэгт үзүүлдэггүй, дэвтрээ хаясан, бичиг баримтгүй зэрэг шалтгаанаар ЭМД-гүй байгаа нь эрүүл мэндийн үйлчилгээнд бүрэн хамрагддаггүйг илэрхийлж байна. Мал аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдэд тархи хөдлөх, ханиад хүрэх, бөөр, нуруу өвдөх тохиолдол байдаг боловч тэдгээрийн 63.0 % нь эмнэлгийн тусламж, үйлчилгээг эм уух төдийгөөр хязгаарладаг байна. Эмийн зардлын 60%-ийг эцэг эх, 20%-ийг ажил олгогч гаргадаг ажээ.

15. Аюултай байдал үүссэн тохиолдолд 39.1% нь бэртэж гэмтдэг боловч тэдний 50 орчим хувь нь л эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чаддаг. Гэмтлийн дотор нүүр, чих, гар, хөл хөлдөх, тархи, нуруу нугас гэмтэх, хөл гар хугарах явдал нэлээд хувийг эзэлдэг байна.

16. Эцэг эхчүүдийн 60 % нь 200 хүртэл бог малтай, 68.6 %-д нь өрхийн орлогын гол эх

үүсвэрийг МАА бүрдүүлдэг гэснээс гадна 2 өрх тутмын 1 нь хүрэлцээтэй орлогогүй гэж хариулжээ. Ийнхүү өрхийн орлого доогуур байгаа нь хүүхдээ сургууль завсардуулж, МАА-д ажиллуулах үндсэн шалтгаан нөхцөл болж байна.

17. Судалгаанд хамрагдсан сургуулийн гадна байгаа /сургууль завсардсан болон дүйцсэн сургалтанд хамрагдаж буй/ малчин хүүхдүүдийн 79 хувь нь эргэж суралцах сонирхол багатай байна. Үүний учрыг 27.6 % нь сургалтын болон дотуур байр, сурах бичгийн хангалт зэрэг сургалтын орчны таагүй байдлаас, 41.7 нь сурлагаар хоцорсон, 19.4 хувь нь улирсан, нас ахисан гэж хүүхдүүд шоолдогтой холбоотой гэж хариулсан байна.

18. Бүх нийтийн боловсролын бодлогын хүрээнд хөдөөд албан бус боловсролын үйлчилгээ үзүүлдэг хэдий ч МАА-д ажилладаг хүүхдүүдийг бүрэн хамруулж чадахгүй байна. Нөгөө талаар хүүхдүүд албан бус хэлбэрээр боловсрол эзэмших хэрэгцээ, сонирхол их байгаа боловч үнэн хэрэгтээ түүний чанар, сургалтын арга барил шаардлага хангахгүй байна. Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 33.9 % АББС-д хамрагддаг боловч тэдний 18.8 % огт уншиж чадахгүй, 33.3 % огт тоо бодож чадахгүй байгаа нь үүнийг нотолж байна.

19. МАА-д хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн нилээд /21.3%/ нь ирээдүйдээ малчин болох сонирхолтой байгаа нь МАА-г үр ашигтай эрхэлвэл тогтвортой орлоготой байх боломжтой гэсэн ойлголт төлөвшиж байгааг илэрхийлж байна. Иймд “малчин”-ы хөдөлмөрийг мэргэжлийн төвшинд тавьж баталгаажуулах шаардлагатай бөгөөд хөдөөд үйлдвэрлэл, боловсрол, мэргэжлийн сургалтын оновчтой хэлбэрийг бий болгох явдал чухал байна.

20. Судалгаанд хамрагдагчдын 39 % нь суурь боловсрол эзэмших үүрэгтэйгээ мэдэхгүй гэж хариулсан нь ямар нэг шалтгаанаар боловсролын гадна байгаа малчны хүүхдүүдэд мэдээлэл хүргэх, тэдний сурч боловсрох эрх, үүрэг, боловсролын ач холбогдлын талаар сургалт явуулах, мэдээлэл өгөх явдал дутагдалтай байгааг харуулж байна. Иймд 21 аймаг, 180 гаруй сумдад төлөөлөлтэй болоод байгаа ХАА-н үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвөөр дамжуулан залуу малчдад боловсролын үйлчилгээ хүргэх ажлыг зохион байгуулж болох юм.

×

×

×

Мал аж ахуйд хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд ажил олгогчтой хөдөлмөр, хөдөлмөрийн нөхцөл, хангамж, эрүүл мэнд, сурч боловсрох, хөдөлмөрийн хөлс урамшуулал авах, нийгмийн хамгаалал зэрэг үндсэн эрхтэй холбогдсон албан ёсны гэрээ хэлцэл хийдэггүй, зөвхөн эдийн засгийн сонирхол дээр санал нэгддэг байна. Энэ нь мал аж ахуйд хүүхдийн хөдөлмөрийг завших, хямд ажиллах хүч болгох нөхцөлийг бүрдүүлж байна.

Хүүхдийн хөдөлмөрийн үнэлэмж тодорхойгүй, тогтмол цалин хөлс өгдөггүй, амрах хугацаа бага байгаа зэрэг нь хөдөөд ажилгүйдэл, ядуурал өндөр, малчдын орлого, амьжиргааны түвшин доогуур байгаагийн нэг үр дагавар гэж үзнэ.

Хөдөлмөр хамгааллын нөхцөл тааруу, урьдчилан сэргийлэх арга хэмжээ хангалтгүй байгаагаас мал аж ахуйн хөдөлмөр эрхлэж байгаа хүүхэд бэртэл, гэмтэл, авах, түүнчлэн бруцеллез, сүрьеэ зэрэг мал амьтнаас хүнд халдварлах өвчнөөр өвчлөх магадлал өндөр байна гэсэн ерөнхий дүгнэлт хийж болох байна.

Энэхүү судалгаа нь хүн ам, мал олонтой бүс нутагт мал аж ахуйн хөдөлмөр эрхлэдэг хүүхэд говь, хээрийн бүсийнхээс илүү байгааг тодруулсан бөгөөд тус салбарт хөдөлмөр эрхлэдэг хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байгааг тогтоосон, мөн мал аж ахуйн салбар дахь далд ажилгүйдэл, ядуурлын улмаас хүүхдийн хөдөлмөрийг завших, боловсрол, эрүүл мэндээр хохироох нийгмийн нөхцөл бүрдэж байгааг мал аж ахуйн хөдөлмөр эрхлэдэг хүүхэд, эцэг, эх, ажил олгогчдыг хамруулан иж бүрэн шинжтэй судалгаа хийж хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар ул суурьтай дүгнэлт гаргаснаараа өмнөх судалгаанаас илүү өргөн хүрээтэй, ялгаатай болов.

### ЗӨВЛӨМЖ

1. МАА-н салбарт хүүхдийн зохистой хөдөлмөр эрхэлэх, тэдний хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангахтай холбоотой эрх зүйн зохицуулалт дутагдаж байгааг харгалзан эдгээр асуудлыг бодлогын төвшинд шийдвэрлэх;

2. МАА-н хөдөлмөр хийдэг хүүхдийг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны наад захын шаардлагыг хангаагүй нөхцөлд цалин хөлсгүй ажиллуулж хөдөлмөрийг нь мөлжих, завших, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний гадна хоцроох зэргээр хүүхэд хохироох явдал түгээмэл шинжтэй байгааг хүүхдийн эрх, эрх ашгийг хамгаалах байгууллагууд анхааралдаа авч уялдуулан зохицуулсан хамтын үйл ажиллагаа явуулах;

3. Хөдөлмөрийн хуулинд зааснаар хүүхэд 15 наснаас, харгалзан дэмжигчтэй бол 14 наснаас хөдөлмөр эрхэлж болохоор заасан боловч нийгмийн даатгалын хуулинд 18 насанд хүрсэн иргэн нийгмийн даатгалд хамрагдах ёстой гэж заасантай зөрчилдөж байгаа тул эдгээр хууль тогтоомжийн хоорондын уялдаа холбоог хангах, мал аж ахуйд хөдөлмөр эрхлэх хүүхдийн жишиг насны доод хязгаарыг шинэчлэх, хүүхдийн эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлэх арга хэмжээ авах;

4. Мал аж ахуйн салбарт хүүхдийн эрхэлж болох зохистой хөдөлмөр болон хориглох тэвчишгүй хэлбэрийн ялгааг тодорхойлж жагсаалт гаргах;

5. Бэлчээрийн уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч малчдын залгамж үеийг тасралтгүй бэлтгэх, тогтвортой ажиллуулахын тулд хүүхдийг багаас нь мал аж ахуйн ажлын баримжаатай, мэдлэг сонирхолтой болгох ажлыг суурь боловсрол болон “малчин” мэргэжлийн боловсрол олгохтой зөв зохистой хослон хэрэгжүүлэх;

6. Монголчуудын уламжлал, нүүдлийн соёл иргэншил, онцлог байдлыг суурин соёл иргэншилтэй хослох, зах зээлийн төлөв байдалтай уялдуулж мал аж ахуйн үйлдвэрлэл хүүхдийн зохистой хөдөлмөрийг дэмжих, тэвчишгүй хөлөмөрийг устгахад оролцогч талуудын хүеүүб ьдүүб бадёоёөааи́ үдб ьдэ́í î ð-í û ã ààòàèääàæóëèàò, ã́дүү́, о́үе́үеөëèéí çàääàð ääðääè ° ðä ьдүүб;

7. Àì üæðääáí û ð° àø èí àì î äóóð, î è í î õ ьдүүбäòýé, í ýí ýäóó àéèüí õ ьдүүбèèä òýí ýì ýè



## СУДАЛГААНЫ БАГ

**Зөвлөх:** Н. Монголмаа  
Г. Дээшин  
Ч. Эрдэнэчимэг

**Судлаачид:** Б.Минжигдорж, Доктор (Sc.D) профессор  
Д.Буянхишиг Доктор (Ph.D)  
Д, Шомбодон, Доктор (Ph.D)  
Л.Даваахүү, Доктор (Ph.D),  
Ц.Одгэрэл

...î î ...

